



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.12.19, МЯГМАР ~ №244 (790)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Сахилгын шийтгэлтэй төрийн албан хаагч урамшуулал авахгүй

Төрийн алба хаагчдын гарт 243 мянган төгрөг очих тооцоо гарч байгаа. >6

Хялбаршуулсан татварын тогтолцоо нэвтрүүлнэ

Монголын эдийн засаг тооцоолж байснаас богино хугацаанд хурдан сэргэж байна. >11



■ Уучлал хүсэх олиггүй арга
■ Калифорнийн түймэр даатгагчдад дарамт болж байна

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын тавдугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- Xopom.com
- lkon.mn
- Caak.mn
- Ubinfo.mn
- Zaluu.com
- News.mn
- Peak.mn
- Medee.mn
- Dorgio.mn

Эх сурвалж: Alexa.com©

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Сэлэнгэ, Хэнтийн зарим суманд хорио цээрийн дэглэм үргэлжилж байна.
Улсын дээд шүүх УХүрэлсүхийг МАН-ын даргаар бүртгэжээ.
УИХ дахь АН-ын бүлэг Төв банкны тухай хуулийн төслөөр Ажлын хэсэг байгууллаа.
Засгийн газрын "Иргэд" олон нийттэй харилцах төв"-д 446,703 иргэн ханджээ.
Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар 300 гаруй мянган хүн саналаа өгчээ.

ЭДИЙН ЗАСАГ

Төлбөрийн тэнцэл 275.9 сая ам.долларын ашигтай гарчээ.
Үндэсний төлбөрийн системийн тухай хууль ирэх оноос хэрэгжиж эхэлнэ.
Нүүрсний экспорт 31.9 сая тоннд хүрч, орлого нь 2.12 тэрбум ам.долларт хүрээ.
ББСБ-ууд хувь нийлүүлсэн хөрөнгөө 2018 оны эхний улиралд нэмэгдүүлнэ.
Хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс 1146.71 нэгж болж, 1.71 хувиар буув.

НИЙГЭМ

Шинэ нисэх буудалд шалгалтын нислэг үйлдлээ.
Хайлаастын уулзвараас Дарь-Эх хүртэлх 1.4 км авто зам ирэх онд ашиглалтад орно.
Мөрөн, Баянхонгор, Алтай чиглэлд нислэг үйлдэж эхэллээ.
Уурхайн гүнд агааргүй болсон гурван иргэний амийг аварчээ.
Шүүхээс Г.Номуундарь хохирогчтой эрүүгийн хэрэг ирээгүй гэж албан ёсоор мэдэгдлээ.

ДЭЛХИЙ

ОХУ-д Ерөнхийлөгчийн сонгуулийн кампани албан ёсоор эхэллээ.
Цөмийн эрчим хүч дэмжихэд зориулан АНУ 400 сая ам.доллар төсөвлөв.
Европын холбоонд элсэхэд саад хийгч Австрийг Турк улс шүүмжиллээ.
Шинэ "Оддын дайн" ням гарагийн байдлаар 450 сая ам.долларын орлого оруулав.
Apple компани iTunes-ийн онлайн худалдааны үйлчилгээг ирэх оноос зогсооно.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.12.19



-9° | -17°

ЯЛИМГҮЙ ЦАСТАЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЖИЛГЭЙН МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУС УНШИХАА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Шуугианы ард жинхэнэ мөнгө хүүлэл хуурай үлдэх нь



Зээлийн хүү дагасан шуугианы ард хуулийн цоорхойд нүүрлэсэн "чимээгүй" мөнгө болох хүүлэл хуурай үлдэх юм биш биз. ▶3

Б.Ганбаяр / ЗГМ©

ЗАХ ЗЭЭЛ

Хуучрах тусам гялалзана

Б.Баярмаа @bayarmaaZGM

Автомашин түүхийн хуудаснаа хамгийн эхэнд бичигддэг 130 гаруй жилийн настай анхны Benz-ээс эхлээд хурд, хүчээрээ гайхагддаг Bugatti-ийн отгон загвар хүртэлх нүд унагам төмөр хүлгүүд нэг дор цугларчээ. Автомашин гурван дугуйтай хөнгөн тэрэг байснаас эхлээд өнөөгийн Bugatti, Rolls Royce, Ferrari болтлоо хэрхэн хөгжсөнийг түүний бичил хувилбар буюу модель загвараас нь харахад тун сонирхолтой.

Европт дэлхийн II дайны дараа автомашины бичил загварыг ▶5

хүүхдийн тоглоомын үнээр зардаг байсан. Харин 1970-аад онд иргэдийн амьдрал дээшилж, цуглуулагчдын тоо хамгийн оргил үедээ хүрсэн бол өдгөө сонирхогчдын тоо, загварын нэр төрөл аль аль нь нэмэгдэж байна. Дэлгүүрийн лангуунд өрөөстэй энэхүү модель загварууд хүүхдийн тоглоом мэт харагддаг ч үүнийг шимтэн сонирхогчдын хувьд тун үнэ цэнэтэй эд. Моделлийг яг эх загварынх нь материал, бүрдэл хэсгүүдээр хийдэг. Зарим нь эх хувилбараасаа ч цөөн хувиар бүтээгддэг тул хүссэн хэн бүхэн авч чаддаггүй.

▶5

FT Трампын шинэчлэл зарим компанид илүү ээлтэй

Эд Крукс, Катрина Мэнсон

Татварын тогтолцоон дахь сүүлчийн саадыг авч хаях хуулийн төслийг Конгресс дахь бүгд найрамдахчууд энэ долоо хоногт баталснаар орлого нь ирэх оноос эрс өснө хэмээн АНУ-ын компаниуд найдаж сууна.

Компанийн татварыг 35-аас 21 хувь болгон бууруулах санаачилгын дүнд тус улсын компаниудын орлого дунджаар 10 хувь өсөх тооцоог шинжээчид гаргаад байгаа юм. Зарим компанийн хувьд орлого бүр 30 хүртэл хувиар өснө.

Татварын "лут" хууль энэ долоо хоногт хүчин төгөлдөр болох талаар АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин ням гарагт ▶9

Fox News-ээр мэдэгдлээ. АНУ-ын холбооны татварын агентлаг - Дотоодын орлогын алба (Internal Revenue Service) "татварын шинэ хуваарь боловсруулж буй"-тай уялдан багагсгасан татварыг ирэх оны хоёрдугаар сараас хурааж эхлэхийг сайд тайлбарлав.

Гадаад дахь хөрөнгөд шинээр тогтоосон татварыг төлдөггүй, хүндсэндээ АНУ-ын дотоодод ажилладаг, харьцангуй өндөр орлого бүхий компаниудад хуулийн шинэчлэл илүү ашигтай тусна. Ялангуяа газрын тос боловсруулагч, төмөр замын болон агаарын тээвэр эрхлэгч, банкууд гол хожигч болж хувирах юм.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ "Оюутолгой" ЗЭСЭЭ ХУМЬЖ, АЛТАА АРВИЖУУЛНА

З.Цэлмэг @tselmegZGM

Тулгуур салбарт томоохон жийрэг болдог "Оюутолгой"-н уурхай ирэх онд зэсийн хүдэр олборлолтоо таван мянган тонноор бууруулахаар төлөвлөжээ. Энэ онд 130-160 мянган тонноор төлөвлөж байсан зэсийн үйлдвэрлэл нь ирэх онд 125-155 мянган тонн болж буурах юм. Гэхдээ цахилгаан автомашины эрэлт нэмэгдэж буй тул зэсийн ирээдүй гэрэлтэй байгаа. Тиймдээ ч ирэх жилүүдэд улбар металлын үнийн төлөвийг өөдрөгөөр тооцсон шинжээчид олон байна. Asia Mining сэтгүүлд "Ирэх жилүүдэд зэсийн үнэ хоёр жилийн өмнөх шиг унахгүй гэдэгт зах зээлийн шинжээчид итгэлтэй байна" хэмээгээд энэ удаагийн үнийн өсөлт бодитой эрэлт дээр бий болсон гэж үзжээ. Цахилгаан батарей бүхий автомашинаас гадна Хятадын эдийн засгийн өсөлт, АНУ-ын Холбооны нөөц бодлогын хүүгээ хэвээр хадгалахаар шийдсэн нь голлох металлуудын үнэд нөлөөлсөн байх талтай аж.

Он гарсаар 25 гаруй хувиар өсөөд буй нэг тонн зэсийн ханш ирэх онд 6100 орчим ам.долларт хэлбэлзэнэ гэж шинжээчид үзэж буй. Олон улсын зарим шинжээчийн таамаг өөдрөг байна.

▶12

MSE ALL 1146.71 1.7%	АЛТ 1258.80 0.29%	ЗЭС 6886 1.37%	10-ЧИНГИС БОНД 99.070 0.04%	5-ЧИНГИС БОНД 100.13 0.06%	АМ.ДОЛЛАР 2425.78	ЮАНЬ 366.83	РУБЛЬ 41.33
-----------------------------------	--------------------------------	-----------------------------	--	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

Үндсэн хууль

Хямралаас гарах гарц нь Үндсэн хуулийн өөрчлөлт биш

УИХ-ын Тамгын газраас төсөл хэлэлцүүлэх дэд ажлын хэсгийг байгуулж, улс орон даяар 21 аймаг, 53 сум, нийслэлийн есөн дүүрэг, төрийн байгууллагуудад нийт 68 удаагийн бүсчилсэн сургалт, хэлэлцүүлгийг хоёр сарын хугацаанд зохион байгуулсан.



Б.Ганбаяр/ЗГМ ©

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг удахгүй боловсруулна

Б.Даваатогтох
@datoZGM

Эрх баригч хүчин мөрийн хөтөлбөргөө Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэ дагуу УИХ-аас Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийг баталж, өнгөрсөн дөрөвдүгээр сард Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар иргэдийнхээ төлөөлөлтэй зөвлөлдөж, саналыг нь авсан юм. Санал асуулгын үр дүнг үндэслэн Зөвлөлдөх зөвлөмөөс зөвлөмж гарган УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг зөвлөмжид үндэслэн УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан билээ. УИХ-аас төслийг олон нийтээр хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Үүний дагуу УИХ-ын Тамгын газраас төслийг хэлэлцүүлэх дэд ажлын хэсэг байгуулж, улс орон даяар 21 аймаг, 53 сум, нийслэлийн есөн дүүрэг, төрийн байгууллагуудад нийт 68 удаагийн бүсчилсэн сургалт, хэлэлцүүлгийг хоёр сарын хугацаанд зохион байгуулж,

дүнгээ гаргасан. Иргэдийн өгсөн санал, эрдэмтэн судлаачид, улс төрийн хүчнүүдийн байр суурь, дүгнэлтэд тулгуурлан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг ойрын хугацаанд багтааж, эцэслэн боловсруулахаар болсон юм.

Энэ хүрээнд өчигдөр УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгтэй хамтран “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол-практикийн асуудлууд” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын дарга М.Энхболд “Нийгэм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол, арга зүйн асуудлууд” болон “Үндсэн хуулийн шинэчлэлийн зарим асуудлууд” сэдвийн хүрээнд өрнөсөн юм. Үүнээс гадна “Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт ба эрх мэдлийн хяналт-гэнцрийг хангах асуудлууд”, “Үндсэн хууль дахь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага ба төрийн албаны тогтолцоог боловсронгуй болгох асуудал” гэсэн сэдвийн хүрээнд ч судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Тухайлбал, академич С.Нарангэрэл Монгол Улсын өнөөгийн байдал нь Үндсэн хуулиас шалтгаалаагүй гэдэг нь бодит үнэн зүйл гэдгийг онцлолоо. Тэрбээр “Монголын өнөөгийн гарцгүй мэт нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүй, оюун санааны гүн хямралаас гарах цорын ганц гарц нь ёс суртахууныг бүхнээс дээгүүр тавих явдал юм. Монгол төрийн үзэл суртлыг бий болгож,

түүнийг цаг алдалгүй бий болгох шаардлагатай” гэлээ. Харин доктор Б.Гүнбилэг улс төрийн хямралыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийснээр засахгүй бөгөөд харин улстөрчдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, намуудыг төлөвшүүлэхэд Үндсэн хуулиас бусад хуулиа ягштал сахих, сахиулах нь зүйтэй гэдгийг тодотгов.

Мөн хууль зүйн шинжлэх

ухааны доктор, профессор Ж.Амарсанаа “Өнөөдөр Монгол Улс Үндсэн хуулийн ба Үндсэн хуулийн бус хоёр яамтай болж байна. Үндсэн хуулийн таван яам, Үндсэн хуулийн бус долоон яамтай болохоор байна гэсэн үг. Ийм байж таарахгүй. 1924, 1960 оны Үндсэн хуульд Засгийн газрын гишүүн хэн байхыг заасан. 1940-1960 оны Үндсэн хуульд яамтай холбоотой асуудлаар таван удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан. Нэгийг нэмдэг, нэгийг нь хасдаг байлаа. Гэхдээ бүгдийг нь жагсааж бичдэг байсан. Тийм учраас яам байгуулахын төлөө Үндсэн хуулиар оролдох хэрэггүй” гэлээ.

Нийтлэлч Баабар “Үндсэн хуульд оруулах шаардлагатай нэмэлт, тодотголууд” илтгэлдээ Үндсэн хуульд хийсэн 1999 оны өөрчлөлт нь тодотгол байсан хэмээн онцлолоо. Мөн өнгөрсөн 25 жилийн турш улстөрчид нь Үндсэн хуулиа санаатай, санамсаргүйгээр зөрчиж ирсэн. Үүний ихэнх нь УИХ болон Засгийн газарт хамаарч байгаа ба хуулиа баримтлахгүй байгаа нь зөрчлийн үндэс болж байна. Энэ мэтээр хуулийг дагаж мөрдөхгүй бол Үндсэн хуулиа өөрчилсөн ч төр, нийгмийн тогтолцооны гажуудал засрахгүй. Тэгээд ч өнөөдөр манай иргэдийн дунд Үндсэн хуулиа мэддэг хүн тун цөөн байна.

Тиймээс иргэддээ Үндсэн хуулиа сурталчлан таниулахын зэрэгцээ эх хуулиа өөрчлөхийн оронд дугаарласан нэмэлт тодотгол гаргавал зүгээр” хэмээн байр сууриа илэрхийлэв. [ЗГМ]

● **2000 оны дордуулсан долоо хэмээн тодотгодог нэмэлт, өөрчлөлтийг буцааж, хуучин заалтуудыг эргээд сэргээх ямар боломж байгааг судалж байгаа.**

● **Монголын өнөөгийн гарцгүй мэт нийгэм улс төр, эдийн засаг, эрх зүй, оюун санааны гүн хямралаас гарах цорын ганц гарц нь ёс суртахууныг бүхнээс дээгүүр тавих явдал.**

● **Яам байгуулахын төлөө Үндсэн хуулиар оролдох хэрэггүй.**

ЭВРИКА

Bloomberg
TV Mongolia

“Эврика” нэвтрүүлгээр урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг.

Энэ удаагийн дугаарт Элмгрин ба Драгсет гэж олонд танигдсан Европын уран бүтээлч Майкл Элмгрин, Ингар Драгсет нарыг танилцуулах болно. Өнгөрсөн 20 жилийн турш тэд Техасаас авахуулаад Трафальгарын талбай, Бээжингээс Берлин, Венецийн Биенналиас Нью-Йорк гээд дэлхийн өнцөг булан бүрийн үзэгчдэд санаанд оромгүй бүтээлүүдээрээ бэлэг барьсаар ирсэн юм.

Пүрэв гараг /2017.12.21/

20:30

11:30 Баасан гараг

09:30/20:00 Бямба гараг

16:30/22:30 Ням гараг

ТОВЧХОН

» БҮЛЭГ

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр хуралдаж, Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөл, ипотекийн зээлтэй холбоотой үл хөдлөх хөрөнгийн асуудлаар мэдээлэл сонсов. Ардчилсан намын бүлгийн гишүүд уг хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг сайтар судлан үзэж, уг хуулийн төслөөр Ажлын хэсэгт байгуулахаар боллоо.

» ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газар өнгөрсөн долоо хоногийн ээлжит хурлаараа гурван яамны Төрийн нарийн бичгийн даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. Тодруулбал, БСШУСЯ-ны ТНБД Ж.Болормаа болон Сангийн яамны ТНБД Б.Нямааг ажлаас нь чөлөөлсөн байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД Л.Баяртулгыг өөрийнх нь хүсэлтээр ажлаас нь чөлөөлсөн. Тэгвэл маргаашийн Засгийн газрын хуралдаанаар дээрх албан тушаалууд дээр нөхөн томилгоо хийхээр болжээ.

» ТОО

95.8

Хувь. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 446703 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл гаргажээ. Үүнээс 427994 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.8 хувийн үзүүлэлттэй байна. 17854 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.8 хувийн үзүүлэлттэй байна. 17854 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.8 хувийн үзүүлэлттэй байна. 17854 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.8 хувийн үзүүлэлттэй байна. 17854 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 95.8 хувийн үзүүлэлттэй байна.

» НАМУУД

МАН-ын XXVIII Их хурал өнгөрсөн сард болж, намын дүрэм болон мөрийн хөтөлбөртөө нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн намын даргаар У.Хүрэлсүхийг сонгосон юм. Тэгвэл Улсын дээд шүүх МАН-ын хүсэлтийг хэлэлцэж, Үндсэн хууль болон Улс төрийн намын тухай хуульд нийцжээ байна хэмээн үзэж, МАН-ын даргаар У.Хүрэлсүхийг, намын мөрийн хөтөлбөр болон дүрэмд орсон өөрчлөлтүүдийг албан ёсоор бүртгэсэн байна.

» ТАЗ

Гэр бүлийн хөгжлийн газрын даргын, Залуучуудын хөгжлийн газрын даргын, Багануур, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд зарласан билээ. Сонгон шалгаруулалтад нийт 94 иргэн бүртгүүлснээс хууль эрх зүйн мэдлэг шалгах сорилын шалгалтад 50 хувь нь тэнцжээ.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» INFO@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Шуугианы ард жинхэнэ мөнгө хүүлэл хуурай үлдэх нь

Мөнгө хүүллийг цэгцлэх шаардлагатай

Г.Байгал
@baigalZGM

Идэр с рүү өдөр өдрөөр дөхөж буй энэ үеийн хамгийн халуун сэдвийн нэг нь зээлийн хүү. УИХ-ын нэр бүхий гишүүний өргөн барьсан “Зээлийн хүүгийн хувийн дээд хэмжээг тогтоох тухай” хуулийн төсөл ирэх саруудад саарал ордны зүг олон хүний анхаарлыг хандуулах нь дамжиггүй. Зээлийн хүүгийн дээд хязгаарт тааз тогтоох нь иргэд төдийгүй эдийн засагчдын дунд ч маргаан дагуулсаар байна. Иймд үүнийг зөв эсхийг одоо шүүн тунгаахаа больё.

Харин зах зээлийн зарчмаар тогтдог энэ хүүгийн түвшинг мөнгө хүүлэлтэй холбон, банкуудын атганд багтдаг тоо мэтээр тайлбарлаж буй нь хэр оновчтой вэ. Тэр тусмаа нэр хүнд бүхий зарим эдийн засагч, санхүүчид зээлийн хүүг жинхэнэ хүүлэл мэтээр тайлбарлаж буй. Мөнгө хүүлэл хэмээх хүйтэн нэрийн дор эдийн засгийн толь, санхүүгийн тусгал болсон зээлийн хүү рүү хүчээр дайрахаар улайрах хандлага хүчээ авлаа. Гэтэл шуугиан дагуулж буй энэ хүүгийн хойно ард түмнийг доройтуулж жинхэнэ хүүлэл үлдэж мэдэх нь. Энэ бол сүүдрийн эдийн засагт үүсч, хуулийн цоорхойд үүрэлдэг ломбард, өдрийн зээл зэрэг эрэлтэд дөрөөрсөн санхүүгийн залилан юм.

Өдгөө хувь хэмжээг хязгаарлахаар улайрч буй, арилжааны банкуудын зээлийн хүү бол зах зээлийн бодит тоо. Хэрхэн тогтдог, энэ зах зээлд хэн хэн оролцдог, хэдий хэмжээний мөнгө эргэлддэг нь тодорхой санхүүгийн системээс “төрдөг” тоон үзүүлэлт. Харин мөнгө хүүлэл, түүний хүүгийн түвшин бол оролцогчид нь ил биш, дүрэм журамгүй, далд эдийн засагт бүрэлддэг зохиомол тоо



Б.Ганбаяр / ЗГМФ

юм. Гэтэл энэ тоогоор тоглож, зах зээлийн нийгмийн зах хязгааргүй орон зайд сул чөлөөтэй оршин тогтнодог мөнгө хүүлэгчдийн тоо олширсоор. Ялангуяа, бичил санхүүгийн зах зээлд гудамжны булан тохой бүрт таардаг ломбард, худалдааны төвүүдэд төвлөрсөн өдрийн зээл олгогчид хүрээгээ тэлсэн. Өдгөө энэ төрлийн бизнес бүр төрөлжиж эхэлснийг томоохон худалдааны төвүүдэд лангуу түрээсэлдэг иргэд хэлж байна. Тухайлбал, дотоодын томоохон худалдааны төвийн нэг “Нарантуул”-д гэхэд өдрийн зээлээр дагнасан 4-5 иргэн сүүлийн таван жил мөнгө зээлж байгаа аж. Үүнээс гадна нэг сая төгрөгөөс багахан хэмжээний мөнгө зээлүүлдэг иргэд ч бий.


Гар дээрээс худалдаа эрхэлдэг иргэдийн 57.7 хувь нь өдрийн зээлтэй

Өдрийн зээлийн талаар уншигч та сонссон байж магадгүй. Эдийн засгийн хүндрэлийн үед хүрээгээ

тэлдэг энэ төрлийн зээл нь 22 хоногоос сарын хугацаатай, 10-20 хувийн хүүтэй. Зээлсэн мөнгөө өдөр бүр бага багаар эргүүлэн төлөх зарчмаар өрнөдөг бичил санхүүгийн нэг хэлбэр. Гэхдээ голдуу далд эдийн засагт өрнөдөг энэ зээл цөөнгүй иргэнд саар үр дагавар дагуулаад байна. “Сарын хугацаатай мөнгө зээлүүлдэг хүүг нь өдөр бүр урьдчилж авдаг системийн цаана санхүүгийн луйвар бий” гэж “Веритас Партнерс” хуулийн фирмийн хуульч М.Ариунболд өгүүлэв.

Иргэд энэ төрлийн эргэн төлөлтөө өдөрт хувааж, бага багаар хийдэг байна. Гэвч өдөр бүрийн орлого тогтмол биш тул зээлийн эргэн төлөлт ч баттай бус. Ингээд зарим тохиолдолд дахин зээл авч, өдрийн зээлээ төлдөг. Энэ мэт урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх явцад зээлийн хүү үржсээр өрийн хэлхээ үргэлжилдэг байна.

Хоёр сая төгрөгийн зээл нэг л мэдэхэд найман сая төгрөг хүртлээ өсчихсөн байсан хэмээн “Нарантуул” худалдааны төвд мах, махан бүтээгдэхүүн борлуулдаг иргэн ярилаа. Хоёр сараар авсан зээлийн хугацаа нь дуусахтай зэрэгцээд өдрийн



зээл олгогчид өрөө нэхэж, орон гэрт нь хүртэл ирээд суучихдаг болсон аж. Ингээд барьцаанд тавьсан лангуу зээмших эрхийн бичгээ зээл олгогчдод өгсөн байна. Ер нь арга мухардсан иргэд амьжиргаагаа залгуулдаг лангуу түрээслэх эрхийн бичгээс гадна хөл дүүжилдэг автомашинаа зарж, өрөө дарах нь энүүхэнд. Ер нь өдрийн буюу хоногийн зээл авсан иргэдийн амьдрал 2-3 жилийн дараа тэр чигээрээ сүйрч, гэр орон, жижигхэн бичил бизнесээ хүртэл алдаж сэтгэл санаа болон бие махбодийн дарамтад ордог хэмээн Монголын

худалдаачдын холбооны тэргүүн И.Тунгалагтуяа ярилаа. Гэтэл гар дээрээс худалдаа эрхэлдэг иргэдийн 57.7 хувь нь өдрийн буюу хоногийн зээлтэй хэмээн тус холбооноос мэдээлж байх юм.

Зохицуулах дүрэм журамгүй, сүүдрийн зах зээлд бугласан бичил санхүүгийн үйлчилгээ Монголын нийгмийн нэгээхэн хэсгийг өрийн хэлхээнд хүлжээ. Цаашлаад цөөнгүй өрхийн амьдралыг хэдхэн жилийн дотор танигдахын аргагүй болтол нь сүйрүүлж дөнгөөд байна. Өдрийн зээлийн үр хөрвөл уг зээлийг авсан иргэнээс гадна үр

хүүхэд, ах дүүг нь хэрж, хүлсэн түүх цөөнгүй.

Сүүлийн жилүүдэд банкны зээлтэй холбоотой маргааны тоо тогтвортой байхад Иргэний хэргийн анхан шүүхээс шийдвэрлэсэн банкаас бусад байгууллагын зээлийн маргаан огцом өссөн байна. Ер нь зохицуулалтгүй зах зээл дэх мөнгө хүүлэл иргэдийн амьдралд энэ мэт сөрөг нөлөө дагуулсаар байна. Өдрийн зээлээс гадна барьцаалан зээлдүүлэх төв буюу ломбардууд ч үүний тод жишээ. Бодлого тодорхойлогчид 30 орчим жил энэ төрлийн үйл ажиллагааг тоолгүй үлдээсэн нь далд эдийн засгийг тэтгэсээр. Энэ зах зээлд хэн хэн оролцдог, хэдэн төгрөг эргэлддэг нь өнөө хэр нууц. Энэ хэрээр татвар, тайлан тооцоо ч бүрхэг хэвээр. Монголын төр олон жил мөнгө хүүллийг мөрөөр нь үлдээсний уршиг ийм байна.

Гэтэл үүнийг ил эдийн засгийн илрэл болсон зээлийн хүүтэй холбох, хольж хутгах нь хэр оновчтой вэ. Сүүдрийн эдийн засгийг илүү сөхөж, эдийн засгийн ил тод байдал, татварын орлогыг нэмэх боломж бий. Гэсэн ч өнөө хэр зээлийн хүүг буулга хэмээн орилж буй улс төрчид эдийн засгийн “шүдний өвчин” болсон мөнгө хүүллийн талаар хэр идэвхтэй хэллэцэж байна вэ. Харин ч мөнгө хүүллийг зээлийн хүүтэй холбох шинжтэй болчихлоо. “Бид, санхүүгийн мөнгө хүүлэлтийн орчноо арилгах хэрэгтэй. Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль гарга. Үүнийгээ иргэний болон банкуудын хуульд суулгаж өгье” гэж УИХ-ын гишүүн асан, эдийн засагч С.Дэмбэрэл хэлж байна.

Татвар төлдөггүй, сүүдрийн эдийн засагт нүүрлэсэн, иргэдийн амьдралаар тоглодог энэ төрлийн мөнгө хүүллийг цэгцлэх шаардлага тулгараад удаж байна. Зээлийн хүү бол хүчээр буулгах бус эдийн засгийн суурь нь илааршиж байж, буурдаг “халууны шил”.

Гэтэл зарим нэгний толгой эргүүлсэн тайлбараас болж Монголын нийгмийн эмзэг зээлийн амьдралыг өрийн хэлхээнд хүлж, сүйрүүлж байгаа жинхэнэ мөнгө хүүллийг хөндөлгүй үлдээхээр байна. Зах зээлийн хуулиар тогтсон зээлийн хүүгээс илүү зах хязгааргүй, хараа хяналтгүй тогтсон мөнгө хүүлэл Монголын эдийн засгийн хамгийн түрүүнд шийдлээ хүлээж буй асуултын тэмдэг биш гэж үү. Зээлийн хүү дагасан шуугианы ард хуулийн цоорхойд нүүрлэсэн “чимээгүй” мөнгө хуурай үлдэх вий. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Судлаачийн үг



Улс орон эгзэгтэй хямралтай мөчид ингэж эвсдэг жишээ манай өнөөгийн амьдралд тусч болохгүй гэж үү.

социалистууд нь христосын ардчиллагчидтайгаа эвсчихээд олон жил тогтвортой төр барьж байна. Нам хагарах нийлэх нь тэнд бишгүй тохиож байсан ч нийгэмдээ гай тариугүй, иргэд нь тоож цочирдохгүй, баялаг амьдрал нь баталгаатай тул улс төр нэгдүгээрт биш. Люксембург хэдий жижиг улс боловч 60 гишүүнтэй парламенттай, Христосын нийгмийн ардын нам (барууны), Социалист ажилчны намтай (зүүний) эвсээд тасралтгүй тогтвортой ажилласан. Нидерландад социалистууд нь барууны либерал-Эрх чөлөө, ардчиллын төлөө ардын нам, зүүний либерал - “Ардчиллагчид-66” намтай эвсээд найман жил засаглал явуулсан гээд бичээд байвал нэг нийтлэлд багтахгүй.

Эвслийн Засгийн газар-Хур туршлага



Германы Социал-Демократ Нам эвслийн Засгийн газар байгуулах тохиролцоонд хүрлээ

Олгонуд Баярхүү
Судлаач профессор

Монголчууд бид ардчиллын 27 жилд юм юм л үзэж яваа. Эвсэнэ, эвслийн гэх ойлголт, анхны төсөөлөлгүй байхдаа л 1990 оны намар МАХН, АН, МҮДН-уудын эвслийн Засгийн газар байгуулж, парламентаа социал-демократар

уидруулж үзсэн. 1996 онд МҮАН-МСДН-ын эвслийн Засгийн газар ажилласан. 2004 онд Үндэсний эв нэгдлийн Засгийн газар байгуулах тухай УИХ-д суудал бүхий хоёр гол хүчний мэдэгдэл монголчуудын нүдийг бүлтгийлж, чихийг сортолзуулсан. Ялангуяа “Үндэсний эв нэгдлийн” гэдэг шинэ тодотгол үг манайхны дасаагүй чихэнд тун чимэггүй буув уу гэлтэй байсансан. Иргэний дайны дараахи эвлэрэлийн үе ч юмуу гэмээр санагдсан. 2008-2011, 2012-2016 онд дан эвслийн Засгийн газрууд ажилласан. Гэтэл дэлхийн жишиг гэж байна уу, гэхдээ хамгийн зөв, эерэг, хуулийн дагуух нь аль вэ гэдэг өнцгөөс дор өгүүлэв.

“НЭГ АРД ТҮМЭН” БА “ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ”

Улс төрийн намуудын гаж буруу тогтолцоо монголчуудыг удирдагчдыг нь дайсагнуулжээ гэдэг дээр одоо нийтээрээ санал нэгдэж эхэлсэн байх. Энэ дайсагнал бол УИХ дахь 1992 оны 71:5, 2000 оны 72:4, 2016 оны 65:9+1+1 харьцааны шууд үр дагавар, сонгуулийн гажиг тогтолцоо гэдэг нь мөн эндээс тодорхой байна. Ийм тэнэг байдалд хүрэхгүйн тулд яах вэ? Барууны ба посткоммунист орнуудын бэлэхэн жишээ байна. Түүнээс ямар ч засваргүйгээр хуулбарлахаас өөр аргагүй.

Тэгж хуулбарлахдаа эхлээд намууд аливаа “изм”-ээсээ салж, үндэсний нийтлэг асуудал, бүр тодорхой хэлбэр “нэгдмэл нэг үндэстэн” гэдэг зарчмаа намынхаа дээр гаргаж тавь гэсэн үг. Нэгэнт л нэгдмэл нэг үндэстэн гэдгээ ухаараад ирэхийн цагт энэ үндэстэнд чинь ямар бэрхшээл зовлон байгаа, түүнийг гэтлэхийн тулд танай намаас эвслийн нөгөө намтайгаа юугаараа ижилсэх, ижилсэхгүй бол ижилсүүлэхийн тулд хэрхэн буулт хийх зэргээ гаргаж тавих хэрэгтэй.

Жишээ болгож эргэн тойрон ямагт дайсагналтай явж ирсэн Израил хэмээх жижиг улсаар жишээлье. Тэнд ядуурал, ажилгүйдэл гэж байхгүй, харин байнга дайны аюул нүүрлэж ирсэн. 1984 онд баруун (Ликуд) зүүний

(Лейбор буюу социал-демократ) хоёр нам хоёр талаасаа угталцан Үндэсний эв нэгдлийн Засгийн газар байгуулж, суудлаа дараахи байдлаар хуваарилж байв.

1) Лейбор намын Ш.Перес Ерөнхий сайдаар хоёр жил

2) Ликуд намын И.Шамир Шадар сайд бөгөөд ГЯЯ-ны сайдаар хоёр жил

3) Хоёр жилийн дараа байраа солих, энэ хугацаанд сайд нарыг яам дамжуулан сэлгэх гэрээ байгуулж байв.

Жишээ нь хөдөлмөрийн нам БХЯ-ыг авсан бол хоёр жилийн дараа Ликудэд байраа тавьж өгөөд, Ликудын мэдэлд байсан ДБЯ-ыг авна гэсэн үг.

Палестины террористууд хүчрэгдэхээ больж, дээр нь Ерөнхий сайдаа (И.Рабин) дотроосоо нухчихсаны дараа бүр шал өөр эвсэл Израилд гарч ирж байв. Ликудын Б.Нетаньяху толгойлсон Засгийн газарт: Ликуд, Үндэсний шашны Мафдал нам, шашны ШАС нам, сионист Цомет нам, орос цагаачдын Израэль ба-Алия нам, “Гурав дахь зам” нам оржээ. Дараа нь энэ эвсэл социал-демократуудаа урин дуудаж, “Үндэсний эв нэгдлээ” санал болгосон ба баруун зүүн, ардчилсан, ардчилсан социалист зэрэг “изм”-үүдээ энэ орон хэдийнэ хэлсэн бололтой юм билээ.

1960-аад онд ХБНГУ-д К.Аденауэр хорвоог орхиж Германы улс төрд маш том онгорхой гарч, бас “Хүйтэн дайн” оргилдоо хүрч, Берлиний хана, Карибын хямрал, Вьетнамын дайн, Чехословакийг Варшавын гэрээний цэрэг мээлсэн зэрэг түүхэн эгзэгтэй мөчид Германы баруун (CDU), зүүн (SPD) хүчнүүд хоёр талаасаа угталцан “Их эвслийн Засгийн газар” гэгчийг гаргаж ирэв. Чингэхдээ,

1) Христосын Ардчилсан Холбооны (барууны консерватив) дарга К.Г.Кизингер Холбооны канцлер

2) Социал-демократын намын дарга В.Брандт Шадар сайд бөгөөд ГЯЯ-ны сайд

3) Эвсэл задарвал аль нэг нь дангаараа Засгийн газар байгуулж болохооргүйгээр заавал Чөлөөт Ардчилсан Намтай (либерал

эвсэх тохиролцоотой.

Үнэмлэхүй эрхийг нэг нам эдэлж болохгүй гэсэн энэ зарчмаар Герман орон 50 гаран жил замнаж байна.

Улс орон эгзэгтэй хямралтай мөчид ингэж эвсдэг жишээ манай өнөөгийн амьдралд тусч болохгүй гэж үү? Ядуурал хоосрол, XXI зууны даяаршлын шуургаанд хамхуул аятай хийсэх аюул манай улсад одоо байхгүй гэж үү? Нийгмээ хоёр хуваан дайсагнуулж, тогтворгүй байдал руу түлхэх гээгүй л бол хувийн ба бүлэглэлийн эрх ямбаа орхиж Герман, Израилийн жишээнээс бид суралцвал яасан юм бэ?

ЭВСЭХ НЬ ДЭЛХИЙД ТҮГЭЭМЭЛЖСЭН ЖАМ ЁСНЫ ҮЗЭГДЭЛ

Эвсэнэ гээд Энэтхэгийн жишээг арай хуулж болохгүй. 1989-1991 онд “Үндэсний фронт”, 1996-1998 онд “Нэгдсэн фронт” гэх 10 гаруй намын эвслийн Засгийн газар ажиллаж байснаа 1998 оноос “Үндэсний Ардчилсан Холбоо” эвслийн 25 намын Засгийн газар ажиллаж байгаад 2004 оны хавар парламентын сонгуульд ялагджээ. Гэхдээ энэ бол нэг тэрбум хүн амтай, 550 улс төрийн намтай, парламент нь 545 гишүүнтэй нүсэр том улс шүү дээ.

Намуудын гаж буруу тогтолцоо монголчуудыг, удирдагчдыг нь дайсагнуулжээ

Манайхан жишээ сургамж авчихмаар посткоммунист ба Бенилюксийн орнуудаар аялаж үзье. Тэнд угаааа намчирхал гэдэг нь алга болсон буюу алга болж байгаа, социал ялгарал нь бас нэг стандарт руу явж буй, ерөөсөө л “Нэг ард түмэн” ба “Үндэсний эв нэгдэл” гэдэг зарчмаар намууд нь ажиллаж, дээр нь сонгуулийн хууль нь туйлын оновчтой тул “эрх барих”, “сөрөг байх” гэдгийг халжээ. Манайхтай ойролцоо хүн амтай

Прибалтийн гурван улс бий.

Латвид “ногоонтон” Ерөнхий сайдтай (дэлхийн бараг анхных нь байх) Цөөнхийн

Баруун төвийн эвсэл: Ардын Нам, Анхдугаар Нам гэсэн хачин засаглал нэг үе байсан. Эстонид 37 настай Европын хамгийн залуу Ерөнхий сайд гэгдэх нэг залуу толгойлсон БНУ-ын төлөө Холбоо, Баруун төвийн реформист нам, Зүүн төвийн Ардын Холбоо намууд төр барьж үзсэн. Баруун зүүнгүй эвсчихсэн нь байгаа нь энэ байсан боловч уу.

Ах дүү Болгарын ард түмэн бүр ч хачин засаглалыг сонгож байлаа. Эзэн хаан байсан хүн хагас зуун жил харьд цагаачилж яваад эргэж ирээд шинэ нам байгуулаад экскоммунист-хуучинсаг энэ улсад засаг авчихсан хачин түүх саяхных.

Үндэсний хөдөлгөөн гэх тэр шинэ нам нь этник турк цөөнхийн намтай эвсчээ. Чехид социал-демократ нам нь төвийн бүлгийн Христосын ардчиллагчид, Эрх чөлөөний Холбоо намуудтай эвсэж баруун зүүнгүй нэг л зорилгын төлөө явж байсан нь мөн л туршлага болохоор. Словакийн баруун төвийн эвслийн Засгийн газарт: Словакийн ардчилсан ба христосын уни нам, Этник унгарчуудын нам, Христосын Ардчилсан Нам, Шинэ ирэгдийн Холбоо гэхчлэн урд хожид сонсогдоогүй намууд нэг дэвэр дор ажиллаж байлаа. Унгарт банкир, нам бус Ерөнхий сайд толгойлсон социалистууд (хуучин коммунист нам) Чөлөөт ардчиллагчдын Либерал Холбоо намын өвөрмөц эвсэл засаг барьж болдгийг нэг удаа харуулсан.

Хорин хэдэн жилийн тэртээ Эдийн засгийн харилцан туслал зөвлөл гэгчид хамт явсан хуучин социалист анд нар маань эвсэх гэдгийг ингэж төвхнүүлж байна. Лав тэнд манайх шиг үхэх сэхээ үзсэн намчирхал байхгүй, ерөөсөө парламентын гишүүн болохыг тэтгэлээ үхэлдэн хүсдэггүй юм байна.

Ардчиллын баялаг уламжлалтай, бидэнд ардчиллыг сургаж илгэж буй Баруун Европт ерөөсөө сөрөг хүч гэдэг ойлголтыг сонгодог утгаар нь үгүй хийчхээ. Бельгид

ХЭН ЭВСЭДГҮЙ ВЭ?

“Эвсэх”, “эвсэхгүй” гэсэн хоёр өмнөө ойлголтын тухай энд ярьж байгаа. “Эвсэхгүй” гэдгийг угаааа эвсэх үндэсгүй, эвсэж болдоггүй гэсэн утгаар ойлгож болно. Эвсэн ч тэр нь тактик, хуйвалдаан, заль мэх, дараагийн алхамд хүрэх шат байх тухайд юм.

1) Коммунистууд. 1917 оны Октябрийн хувьсгалын дараа Ленин, Троцкий тэргүүтэй большевикууд хувьсгал хамтран хийлцсэн Эсер, меньшевикуудийг 1919 он гэхэд бүрэн шахаад, иргэний дайнтай цуг алж устгаж арилган, түүхээс арчсан, 1930-аад онд коммунист нам доторхи фракцуудаа зүйл дуусгасан.

2) Нацист, фашистууд. 1932 онд Рейхстагийн сонгуульд Гитлер тэргүүтэй нацист нам 37.2 хувийн санал авч, эвслийн Засгийн газарт 12 суудлын гуравыг авсан ч Үндсэн хуулийн цоорхойгоор 1933 онд дахин сонгууль хийн “Бид засгийн эрх авбал тэндээс зөвхөн үхсэн хойноо л гарна” хэмээх Геббельсийн афоризмаар сөрөг гэх бүх хүчнээ устгаж, газрын хөрснөөс арчсан.

3) Авторитари, монархи, теократ, дарангуйлах засаглалтай ямарваа улсад “Эвслийн Засгийн газар” гэх ойлголт байхгүй. Жишээ нь, Хятад, Хойд Солонгос, Вьетнам, Куба, Иран, Казахстан ба Төв Азийн бусад улсууд гэхчлэн.

4) Ерөнхийлөгчийн хатуу засаглалтай, парламентаризм нь хоёрдугаарт явдаг ОХУ, Беларусь, БНСУ, Латин Америкийн улсуудад Засгийн газраа хэрхэн бүрдүүлэх, ямар намаас сайд тавих нь чухал биш. Жишээ нь ОХУ-д Засгийн газрын бүх гишүүд намын харьяалалгүй байгаа нь нэг талаасаа зөв практик юм.

5) Хоёр намын уламжлалт засаглалтай, хэзээ ч олон намын тогтолцоо байгаагүй, АНУ, Британид эвслийн Засгийн газар байгуулсан тохиолдол байхгүй, бий болохгүй, тийм ойлголтгүй.

6) Улс төрийн аливаа намыг хуулиараа хориглосон улсад ийм практик байхгүй. Жишээ нь Иордан, Бутан, Арабын Эмиратууд, Африкийн зарим орныг нэрлэж болно. Нэгэнтээ л Монгол Улс барууны парламентаризмыг сонгон авч, нэг биш, хоёр биш, олон намыг хуульчилсан л бол “Эвслийн Засгийн газрын” сонгодог практикийг хөрсөн дээрээ суулгах ёстой юм. 2020 онд ч хэрэг болох юм бил үү, хэн мэдлээ...

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сурталчилгаа, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр байнгын харилцагчдын хүрээллийг тогтмол тэлэх, санаачилга гаргах, гэрээ хэлэлцээр хийх, албан бичиг боловсруулах, танилцуулах чадвартай байх
- Борлуулалтын хэлцэл хийх, уулзалт зохион байгуулж, танилцуулга бэлтгэх, танилцуулах
- Байгууллагаас захиалсан сурталчилгааг хүлээн авах, хянах, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх
- Байгууллагын бусад ажилтнуудтай хамтран ажиллах

Asia Mining

MAGAZINE

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг үеийн өөрчлөлтийг мэдэрч, шинэ санаачилга гаргах, үүнийг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах чадвартай байх
- Шинийг санаачлагч, багаар ажиллах чадвартай, тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзэлтэй байх
- Уул уурхайн салбарт мэргэжлээрээ ажиллаж байсан бол давуу тал болно
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх
- Англи хэлний өндөр мэдлэгтэй байх ба хятад эсвэл орос хэлийг хоёрдогч хэлээ болгон эзэмшсэн бол давуу тал болно
- Холбогдох чиглэлээр мэргэжил эзэмшсэн, эсвэл ажлын туршлагатай байх

Хэрэв та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол англи эсвэл Монгол хэлээр бэлтгэсэн танилцуулгаа доорх хаагаар илгээгээрэй. Бид тантай холбогдож, дараагийн алхмуудыг хэлэлцэх болно.

ХОЛБОО БАРИХ: 9913 5112 info@asiamining.mn хаягаар холбоо барина уу.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэсний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Даваагтох
Утас: 99901637

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртгох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Байрсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Бло Скай тауэр” 407 тоот Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131, Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Баяртгох

Зах зээл



Монголчууд хуучны орос загварыг хамгийн их сонирхдог. Оросын Volvo-гийн моделиуд 200-290 мянган төгрөгийн үнэтэй байна.

С.Батсайхан / ЗГМ©

Хуучрах тусам гялалзана

Сонирхогчдын тоо, загварын нэр төрөл хоёр нэмэгдэж байна

Үүнийг дагаад үнэ нь ч бас чамлахааргүй өндөр. Үүдээ нээгээд жилийн ойтойгоо золгох гэж буй “Model car” дэлгүүрт 20 мянгаас таван сая хүртэлх төгрөгийн үнэтэй янз бүрийн “бичил” автомашинууд өрөөстэй. Шилэн хоргон дахь тас хар өнгөтэй Rolls Royce Mansory-гийн модель гэхэд дэлхийд ердөө 20 ширхэг байдаг бөгөөд нэгийг нь тус дэлгүүрт 2.7 сая төгрөгийн үнэтэй худалдаалж байна. Түүнчлэн Lamborghini Aventador LP720-4 750 мянга, час улаан Ferrari нэг сая, Bugatti Veyron Pur Blanc 1.5 сая, Rolls-Royce Phantom Drophead Coupe 4.5 сая төгрөгийн үнэтэй. Дээр дурдсан Benz-ийн хамгийн анхны загварын моделийг 430 мянган төгрөгөөр худалдаж авах боломжтой. Харин хуучны Volvo 200-290 мянган төгрөгийн үнэтэй байна.

“Model car” дэлгүүрийн захирал Ч.Оч “Монголын хувьд зах зээл нь жижиг, сонирхдог хүн цөөн. Гэхдээ хүн цуглуулгаа эхлэхдээ мөнгө санхүүгийн асуудлаа шийдчихсэн байдаг. Манай дэлгүүр 40 гаруй байнгын үйлчлүүлэгчтэй. Ихэнх нь амьдрал нь тогтсон, хоббидоо цаг, мөнгө зарцуулах боломжтой олны танил хүн байдаг. Энэ бизнес хүмүүсийн хобби,

сонирхол дээр үндэслэдэг учраас ирээдүйд улам хүрээгээ тэлнэ гэж харж байна” гэлээ.

“Model car”-ийн хувьд янз бүрийн орноос бараагаа татдаг. Гурван сард нэг удаа бараагаа татахдаа 40-60 сая төгрөгийн үнэ бүхий 50 орчим төрлийн 100 орчим моделийг оруулж ирдэг байна. Манай улсад хамгийн ойр байдаг моделийн “зах” нь БНХАУ-ын Гуанжоу хотод байдаг Toy house юм.

Цуглуулагчид ихэнхдээ олны танил хүмүүс байдаг

Тус дэлгүүр нь 50 мянга орчим нэр төрлийн бараатай, Азид хамгийн томд ордог автомашины моделийн дэлгүүр юм байна. Ч.Оч “Ер нь автомашины моделийн үнэ үйлдвэрийн үнээсээ шууд хамаардаг онцлогтой. Модель үйлдвэрлэгчид албан ёсны борлуулагч нартаа нэг тогтсон үнээр худалдаалдаг. Хятадад 100 ам.доллараар зарж байгаа бол манай дэлгүүрт ч мөн адил үнээр өгдөг. Үүн дээр гааль болон бусад татвар, тээврийн зардал дээр таван хувийн ашиг нэмж зарж байгаа” гэв.

Модель цуглуулагчид хамгийн сүүлийн загварыг сонирхдог. Аль болох ховор, нандин, үнэ цэнэтэй эдийг цуглуулгадаа нэмэхийг зорьдог. Түүнчлэн сүүлийн үед үүнийг бэлэг дурсгалын



Чехийн 1980 оны Karosa автобусны загварыг жилд 100 ширхэгийг үйлдвэрлэдэг.



Моделийг яг эх загварынх нь материал, бүрдэл хэсгүүдээр хийдэг.



Bugatti-гийн оны ялгаатай загварууд.

зориулалтаар худалдан авах нь ихэсчээ. Ялангуяа хуучны орос автомашины моделиудаар албан

өрөөгөө гоёх нь олон болжээ. Энэ бизнесийн барааны цэсэд легио модель хүч түрж байгаа

юм. Угсардаг бичил загварууд нь тоглоом гэхээсээ илүү цуглуулгын зориулалттай. Бүх араа,

шүд, эрэг шургыг эвлүүлдэг бөгөөд бусад моделийн адил “жинхэнэ” сэлбэг хэрэгслүүд байдаг. Тухайлбал Porsche 911 GT3 RS загварын легио модель 42 мянган деталь хэсэгтэй. Үүнийг заавар номноос харж эвлүүлэхэд долоо хоног зарцуулдаг аж. 16-аас дээш насныханд зориулсан энэ хувилбарыг Монголд тун цөөн хувиар зарж байгаа гэв.

Нэмж хэлэхэд, автомашины моделиуд хүүхдийн тоглоомоос үнэ, хийц, материал зэрэг олон зүйлээрээ ялгаатай. Хамгийн гол нь худалдан авч буй хүндээ танин мэдэхүйн чухал ач холбогдолтой. Аливаа зүйлд тууштай, тэвчээртэй, нямбай зан чанартай болдог аж. Шинэ загвар авахын тулд мөнгөө хуримтлуулах шаардлага гардаг тул санхүүгийн сахилга баттай болгодог гэж цуглуулагчид үздэг. Мөн автомашины загварын сүүлийн чиг хандлага, авто техникийн нарийн мэдлэгтэй болдог давуу талтай аж.

Одоогоор Монголд энэ нь шинэ зах зээл. Хүний өдөр тутмын хэрэгцээний тоонд орохгүй ч энэ зах зээлийн орон зайг өөдрөгөөр харж болно. Цуглуулагчдын сонирхолд үндэслэсэн энэхүү бизнесийн үнэ цэнэ өдөр ирэх тусам өсдөгөөрөө онцлог. Тухайлбал, 2012 онд 800 орчим мянган төгрөгөөр худалдаж авсан Bugatti-ийн бичил загвар өдгөө дөрвөн сая төгрөгийн үнэд хүрээд байна. Тансаг зэрэглэлийн автомашинуудын загвар цөөн тоотой гардаг учраас ийнхүү үнэ цэнэ нь цаг хугацаа өнгөрөх тусам нэмэгддэг аж. [ЗГМ]

The David Rubenstein Show



Коллин Пауэлл
Генерал (чолоонд гарсан)

Пүрэв гараг /2017.12.21/

22:00

14:00 Баасан гараг

21:00 Бямба гараг

14:00 Ням гараг

Bloomberg TV Mongolia



Нийгэм

ЗГМ: ТОДРУУЛГА

Сахилгын шийтгэлтэй төрийн албан хаагч урамшуулал авахгүй

Төрийн алба хаагчдын гарт 243 мянган төгрөг очих тооцоо гарч байгаа

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал болгож 300 мянган төгрөг олгохоор шийдвэрлэж, шаардлагатай хөрөнгийг энэ оны төсвийн тодотголд суулгасан. Тэгвэл улсаас олгож буй үр дүнгийн урамшууллыг ямар журмаар олгох талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригос тодруулла.

-Төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг ямар журмаар олгох вэ?

-УИХ-ын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол өнгөрсөн арваннэгдүгээр 9-нд батлагдсан. Тогтоолын 1.1 дэх заалтад Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газарт 2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаал-



Б.Ганбаяр / ЗГМӨ

тан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох арга хэмжээ авахыг даалгасан байгаа. Энэ дагуу Засгийн газраас төрийн албан хаагчдад олгох үр дүнгийн урамшууллыг олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

-Төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад бүх төрийн албан хаагч авна гэж ойлгож болох уу?

-Тэднээс гадна сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй байгаа төрийн албан хаагчид урамшуулал олгохгүй байхаар оруулсан.

-2017 оны үр дүнгийн урамшуулал олгоход нийт хэчнээн төгрөг зарцуулах вэ?

-Энэ оны урамшуулалд 55.6

тэрбум төгрөг зарцуулна.

-Хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг урамшууллаас суутгах уу?

-Цалин хөлс нь Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт зааснаар үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал гэсэн үндсэн дөрвөн бүрэлдэхүүнтэй байдаг. Урамшуулал нь цалин хөлсний бүрэлдэхүүнд багтаж байгаа учраас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад зааснаар энэхүү урамшууллаас хувь хүний орлогын албан татвар 10 хувь, төрийн албан хаагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл 10

Урамшууллыг чөлөөтэй байгаа болон орлон ажиллаж байгаа ажилтны аль алинд нь тухайн жилд ажилласан хугацаа буюу сарыг нь харгалзан хуваарилах нь зүйтэй.

шууллын зардал тусгасан байгаа.

-Урамшууллыг зарим төрийн байгууллага ялгавартай олгоно гэж байгаа. Ийм заалт журамд бий юу?

-Засгийн газрын хурлаас гарсан шийдвэрт төрийн албан хаагчдад урамшууллыг ялгавартай олгох талаар заалт тусгаагүй.

-Төрийн албан хаагчид урамшууллаа энэ ондоо багтаж авах боломжтой юу?

-Ондоо багтаагаад олгож дуусах ёстой.

-Орон нутгийн ИТХ-ын дарга нар үр дүнгийн урамшуулалд хамрагдах уу?

-Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга төрийн өндөр албан тушаалд хамаарах тул урамшуулалд хамрагдахгүй.

-Энэ онд ажиллаж байгаад жирэмсний амралтаас авсан, эсвэл түр хугацаанд чөлөө авсан албан хаагчдад энэхүү урамшууллыг олгох уу?

-УИХ-ын 2017 оны төсвийн тодотголд төсвийн байгууллагын зөвхөн төсөвт тусгагдсан орон тоонд үндэслэн 300 мянган төгрөгийг олгохоор хөрөнгийг тусгасан. Тийм болохоор урамшууллыг чөлөөтэй байгаа хүнд болон түүнийг орлон ажиллаж байгаа ажилтанд давхардуулан олгох боломжгүй. Иймд 300 мянган төгрөгийн урамшууллыг чөлөөтэй байгаа болон орлон ажиллаж байгаа ажилтны аль алинд нь тухайн жилд ажилласан хугацаа буюу сарыг нь харгалзан хуваарилах нь зүйтэй. [ЗГМ]

хувийг суутгана. Ингэхээр төрийн алба хаагчдын гарт 243 мянган төгрөг очих тооцоо гарч байгаа.

2018 оны улсын төсөвт тодорхой хэмжээний урамшууллын зардал тусгасан

-Үр дүнгийн урамшууллыг жил бүр олгох уу. Эсвэл энэ нь нэг удаагийн арга хэмжээ юм уу?

-Энэ нэг удаагийн арга хэмжээ биш. Ирэх 2018 оны улсын төсөвт тодорхой хэмжээний урам-

ШИНЭ НОМ

Цэнхэр гарагийн ид шидийн нууц “Гайхамшигт ой”-д оршвой



Амьтай бүхний амьдралын төлөөх тэмцэл, экосистемийн бат бөх гинжин хэлхээг бид ойгоос л тольдон харах боломжтой.

салбарт манлайлдаг эрхмүүд ч ойн тухай өөрийн нууцаа уншигч танд дэлгэсэн байна.

УИХ-ын гишүүн асан Г.Уянга тус номын хуримын үеэр “Монголын ой жил ирэх тусам багасаж байгаа одоо үед энэ гайхамшигт ертөнцийн нууцлаг амьдралын талаар өгүүлсэн энэхүү ном нь маш үнэ цэнэтэй бүтээл болж буй” хэмээн онцолсон.

Мөн БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Тунгалаг “Хүн төрөлхтний ойн бүхий л хэрэглээ болох байгалийн дагалдах баялаг, эм бэлдмэл, гоо сайхны бүтээгдэхүүнийг моддын генетик нөөцөөс гарган авдаг. Ийм нарийн зүй тогтолтой баялгийг хайр найргүй устгаж байгаа нь харамсалтай. Тодорхой хэлбэл, хүмүүс ой модны гайхамшигийг мэдэрч, үнэт чанарыг нь ойлгохгүй байгаа учраас л хоромхон зуур үгүй хийж байгаа хэрэг. Тиймээс бидний бүтээсэн энэхүү ном тэдгээр хүмүүст эх орныхоо гайхамшигт ойг тольдон ойлгоход туслах болно” гэж хэлсэн юм. Мөн тэрбээр энэхүү ном энгийн хүмүүс уншихад маш сонирхолтойгоор бичсэн тул ЕБС-ийн сурагчдын сургалтад ч ашиглах боломжтойг онцолсон.

Ойн нууцыг уншигч таны өмнө нээсэн “Гайхамшигт ой” номд ой, амьтдын хоорондох харилцаа, өөрийгөө хэрхэн нөхөн сэргээдэг, шим тэжээл, өөрчлөгдөн буй төрх зэргийг нийт есөн бүлэг болгон ихэд сонирхолтойгоор дүрслэн өгүүлжээ. Номын эхний бүлэгт ой модод яг л хүн, амьтан шиг хувьсдаг, тэдний дуртай тансаг үнэрийг ялгаруулж, өнгө будгийг гайхамшигт хослолоор хүний мэлхийг хэрхэн баясадаг тухай уран яруу боловч энгийнээр өгүүлж байна. Бас ой хөлгүй атлаа нүүдэг тухай та анх удаа энэ номноос мэдэх боломжтой гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Энэ мэт ойн баялаг гайхамшигтай амьдралын талаар бусад бүлэгт эмх цэгцтэй, уншууртай хүүрнэсэн байна. [ЗГМ]

Уншигчдад зориулан ойн гайхамшигийг өгүүлсэн анхдагч бүтээл болжээ

Цэнхэр гарагийн гурваны нэгийг буюу дөрвөн тэрбум га газрыг эзэлдэг ойд чухам ямар гайхамшиг, агуу ертөнцийн нууц оршдог вэ. Ойгоос эгшиглэх уран хөг аялгуу, чамин тансаг үнэр, өнгө будгийн төгс хослол чухам хаанаас бий болж байна вэ. Эдгээр асуултад зөвхөн “Гайхамшигт ой” танд хариулах болно. Учир нь амьтай бүхний амьдралын төлөөх тэмцэл, экосистемийн бат бөх гинжин хэлхээг бид ойгоос л тольдон харах боломжтой гэж

“Гайхамшигт ой” номын зохиогч, “Балдорж” шагналт, байгаль орчны сэтгүүлч Ц.Цэвэнхэрлэн өгүүлжээ.

Ойн нууцад нэвтрэх замыг дөтөлсөн “Гайхамшигт ой” бүтээл уншигч таны оюуны мэлхийг баясахаар мэндэллээ. Монгол орны хойд хагасыг эзлэн орших ойн ид шидийн тухай сонирхолтой бөгөөд хялбараар өгүүлэх энэхүү бүтээл нь энгийн уншигчид төдийгүй хүүхэд залуучуудад зориулсан анхны бүтээл болсноороо онцлог хэмээн үе үеийн байгаль хамгаалагчид, ойчид онцолж байгаа юм. Мөн Олимпийн аварга Н.Түвшинбаяр, Дэлхийн миссийн тэмцээнд оролцож байсан Б.Баярцэцэг, “Монос” группийн Ерөнхийлөгч Л.Хүрэлбаатар гээд бүхий л

ХӨТӨЧ

Мэдээллийн санг бүх чиглэлд ашиглах бүрэн боломжтой

Монгол Улсын нийт газар нутгийн эрдэс баялгийн нөөц, хөрсний чийгшил, цэвдэг, түүх археологийн дурсгал, газар хөдлөлтийн байдал, цаг агаар гээд 34 төрлийн мэдээллийг агуулсан “Инженер геологийн мэдээллийн сан” ашиглалтад оров.

Энэхүү мэдээллийн сан нь Үндэсний орон зайн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд хийгдэж байгаа юм. Үүнийг хот төлөвлөлт, барилга байгууламжийн төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэстэй хийх, гүний усны түвшинг тогтоох,

цэвдэгийн гэсэлтийг судлах, газар хөдлөлийн эрчим, давтамжийг судлахад тусална.

Түүнчлэн бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, газрын төлөв байдал, геологи орчны мониторинг хийхэд чухал мэдээлэл болох төдийгүй сургалт, эрдэм, шинжилгээ, олон нийтийн хэрэглээнд ашиглах өргөн боломжтой аж. Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан мэдээллийн санг уул уурхай, газар тариалан, мал аж ахуй гээд бүхий л салбарт ашиглах боломжтой

гэдгийг дуулга.

Монгол Улсын зүүн аймгууд харьцангуй дулаан байдаг бол баруун аймгууд 10-20 хэмээр хүйтэн байдаг. Тэгэхээр Увс, Ховдод дулаан орон сууц барихын тулд зүүн аймгуудынхаас илүү зузаан ханатай барилга барих шаардлагатай. Иймээс зузаан ханатай барилга барихын тулд суурийн дам, армагур, төмрийн хэмжээг нэмэх хэрэгтэй болно. Энэ мэтээр тухайн үйл ажиллагаа явуулах орчин нөхцлөөсөө эхлээд бүгдийг нарийн тооцоолох боломж бүрдэх аж. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-12-19

Тендер шалгаруулалтын нэр:

ДЦС-4 ТӨХК-ийн инженерийн барилга байгууламжийн ашиглалтын болон цэвэрлэгээний үйлчилгээ үзүүлэх ажил

Тендер шалгаруулалтын дугаар: АУ-2017- 11

“ДЦС-4”ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос: “ДЦС-4 ТӨХК-ийн инженерийн барилга байгууламжийн ашиглалтын болон цэвэрлэгээний үйлчилгээ үзүүлэх ажил” гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалт нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх 2015, 2016 он /

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгосон үнийн дүнгийн 10%-аас багагүй байх

Аудитара баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил /2015, 2016 он / Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Жил бүр хоёр тэрбум төгрөгийн үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он/

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: тусгай зөвшөөрөл шаардлагатай.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-аас багагүй дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 1 дүгээр сарын 19-ны 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 1 дүгээр сарын 19-ны 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо. “ ДЦС-4” ТӨХК. Захиргааны I байр 3 давхар 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас/факс: 70001357

ZGM DAILY

TRQ releases 2018 production and financial guidance

Oyu Tolgoi copper production estimated to be around 125-155 thousand tons.

IMF advises to further strengthen the economic growth

The next working group to come near the end of January 2018.

MNT 55.6 billion to be allocated to public servants

Public servants to receive MNT 250 thousand at hand

Agricultural export reaches USD 1.1 billion

Meat and meat products export doubles that of last year.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

The Supreme Court registers the amendments to Mongolian People Party's rules and regulations.

A research conference under the theme "Theoretical and practical issues of amending the Constitution of Mongolia" held.

Ulaanbaatar City Tourism Department informs, hotel permissions will not be granted until January 20, 2018.

ECONOMY

A total of 16 million tons of coal imported through Gantsmod border checkpoint, informed the General Administration of Customs of People's Republic of China.

The export of agricultural products reaches USD 1.1 billion. Meat and meat products export is showing the highest growth of MNT 108 billion, which is 2.2 times higher compared to last year's total meat exports.

Officials led by Bayartsaikhan Nadmid, Governor of the Bank of Mongolia, attends the 53rd meeting of Southeast Asian Central Banks Governors' Conference.

SOCIETY

The Khushig Valley Airport, a newly established international airport, successfully conducted their first test flight on December 16.

Child crime prevention department has been established under the Crime Suppression Department of National Police Agency.

Union of Mongolian Artists was awarded the Order of Sukhbaatar on the occasion of the 75th anniversary of inception and growth of contemporary fine arts in Mongolia.

With an aim to participate in the new category of ice climbing in the Tokyo-2020 Olympic Games, Mongolian National Climbing Federation held a national ice climbing tournament "Ice Challenge 2017".

Oyu Tolgoi intends to double gold mining in 2018



Ganbayar.B / ZGM©

Operation costs to reduce to USD 700 million

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Turquoise Hill Resources LLC (TRQ), Rio Tinto's stakeholding company listed on TSX, plans to extract 240-280 thousand ounces

of gold from Oyu Tolgoi mine in 2018 and estimates the operation expenses to reduce by 2.8 percent.

TRQ's initial plan was to produce 100-140 thousand ounces of gold in 2017. As of the third quarter of this year, the company processed 36.9 thousand tons of copper, 31 thousand tons of gold and 239 thousand ounces of silver from a total of 170 thousand tons of concentrate.

However, the company estimates Oyu Tolgoi copper production to reduce next year. The

copper production, which was previously planned at 130-160 thousand tons, is expected to be around 125-155 thousand tons in 2018.

This year's estimated operating cost was USD 720 million due to the lower metal grade in the concentrates and logistics expense. Thus, the operating costs for 2018 are expected to drop down to approximately USD 700 million.

Furthermore, the capital expenditures were estimated to be USD 150 million for open-pit operations, while the underground

development cost will increase to about USD 1.1-1.2 billion. The main drivers of the increase are equipment purchases and maintenance componentization, reported TRQ. Open-pit operations are expected to continue in layer 4 and 6. In addition, stockpile ore will continue to be processed during 2018.

Located 550 km south of Ulaanbaatar and 80 km north of Chinese border, Oyu Tolgoi is 34 percent owned by Mongolian Government and 66 percent by TRQ LLC, while Rio Tinto holds

51 percent shares of TRQ.

Oyu Tolgoi is expected to be the world's third-largest copper mine at peak production in 2025. Average annual production from 2025 to 2030 is expected to be more than 550 thousand tons.

According to the Minister of Mining and Heavy Industry Sumiyabazar Dolgorsuren, the mining exports form 78.8 percent of total domestic exports, collecting MNT 1.4 trillion into the State Budget. As of the third quarter of 2017, Oyu Tolgoi LLC paid a total of USD 120.5 million for tax. [ZGM]

INTERVIEW

Neil Saker: IMF to introduce simplified tax system

In accordance to the IMF's approval of USD 79.1 million disbursement, the Official Gazette has held audience with Neil Saker, the IMF's Resident Representative for Mongolia.

How would you assess Mongolia's implementation of its obligations for the EFF?

After completing the first and second review under the program, the IMF's Execu-

tive Board approved USD 79.1 million disbursement. The combination of strong policy implementation and a supportive external environment has helped the authorities over-per-

form on all of the quantitative targets under the program. Hence, the economic indicators are improving. In other words, Mongolia's economy is recovering faster than our estimation. The implementation of the program was good.

What are your outlook for next year? Were there any changes in the initial forecast?

Many major changes were shown in the economy since the implementation of the program. First of all, the economy has been stabilized successfully. The GDP growth was much higher than our anticipated level. The growth is expected to be at 3.3 percent at the end of 2017 and 4.5 percent next year. We were careful on our estimation for the economic growth. Policy implementation has had positive impact on the economy in a very short period. But it is important to further improve and strengthen the economic growth.

The economy grew by 5.8 percent in the first three quarters. What were the key factors to this growth?

The supportive external environment had major impact in it. Specifically, China's high coal demand had additional support. Aside from the market conditions, the investors' confidence recovered and was reflected on the business environment. MNT has been stabilized and FDI has increased partially driven by donations of donor countries. Furthermore, the interest rate of Mongolian Government bond has lowered

significantly. Government bond yield in the domestic market has fallen from 18 to 11 percent, thereby reducing expenditure. Foreign currency reserves have risen sharply, reaching USD 2.5 billion and is expected to increase further.

Were there any significant changes in the budget?

There has been some positive changes in the fiscal policy. In specific, the budget expenditure was halved, equalling 7.5 percent of the GDP. The Government took certain steps in reducing the budget deficit within the frames of the EFF program. Additionally, specific actions were taken to increase budget revenue and one of them was the tax regulations.

Will the increase in tax interfere with the opportunities for sustainable growth?

The IMF has been supporting the tax reform. The key principle is to increase tax for high-income people through different tax brackets. A major reform is expected in the tax system. The aim is to promote equality and support economic growth. Many IMF consultants are working on this to introduce a simplified tax system.

When will the third review take place?

The next team will come near the end of January 2018. The program is being evaluated each quarter. It means that a working group will be assigned every three months. The program is moving to the next preparatory work after the Executive Directors' meeting. [ZGM]

SOCIETY

Public servants' incentives to be granted within the year




Ganbayar.B / ZGM©

The 2017 Budget Amendments, which was approved on November 9, stated to grant MNT 300 thousand incentives to public servants with the exception of high officials, judges and prosecutors.

According to Chinzorig Sodnom, Minister of Labour and Social Protection, a total of MNT 55.6 billion will be allocated for the incentives. As stated on the Law on Labour, individual income tax and social insurance premium will be deducted from the incentive since it counts as a salary component. Thus, the public servants will receive a total of MNT 250 thousand at hand, which will be allotted within the year.

"The incentive is not only a one-time premium, but will be granted annually. The employees who have received disciplinary punishments this year, or the disciplinary sanctions have not yet been expired, will not be able to receive the grant. Head of the People's Representative Khural counts as a high official; hence, the incentive will not be granted. As for an employee who is on leave, the amendments included only the current vacancy in the budget, so the incentive will be granted to either the employee who is on leave or their replacement, depending on their worked hours within the year," said Mr. Chinzorig Sodnom. [ZGM]

ZGM: INFOGRAPHIC



Лавлах

УЛААНБААТАР

Хайлааст Дарь-Эхийг холбоно

М.Мөнх
ЗГМ

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хайлаастын уулзвараас Дарь-Эхийн зам хүртэл 1.4 км авто зам, 57 урт метр гүүрийн хамт барих ажлын хүрээнд 2017 онд төлөвлөсөн хуваарийн дагуу гурван алгасалтай 57 урт метр төмөр бетон гүүрийн тулгуур, суурь, 21 дам нурууг цутгаж, далан сувгийн бэхлэгээний болон гүүрийн хоёр талын холбох замын газар шороо, далангийн дүүргэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тус замын ажил нийт 31 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн бөгөөд ирэх онд ашиглалтад орох юм. Энэхүү замын гуравдугаар хэсгийг барьснаар Дарь-Эхийн зам болон Чингэлтэйн гудамжийг холбосон шинэ холбоос зам үүсч, улмаар хотын хойд хэсгийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ачаалал буурч, жигд хуваарилах болон гэр хорооллын дахин төлөвлөлтийг хурдасгах чухал ач холбогдолтой. Гүйцэтгэгчээр “Мотор сервис” ажиллаж байна. [ЗГМ]

ТЕХНОЛОГИ

iMac худалдаанд гарна



AppleInsider вебсайтын мэдээлснээр өнөөдөр Apple компани өөрийн түүхэн дэх хамгийн хүчирхэг iMac Pro компьютерийг худалдаанд гаргах гэж байна. Өнөөдөр Европын орнууд болон АНУ-ын дэлгүүрүүдэд найм ба 10 цөм бүхий хоёр төрлийн процессортой хувилбарууд зарагдаж эхлэх юм. Харин 2018 оноос эхлэн 14 ба 18 цөмийн процессортой загварууд худалдаанд гарах болно гэдгийг шинэ iMac-ийг туршиж үзсэн анхны хүмүүсийн нэг, блогер Маркес Браунли хуваалцжээ.

Шинэ iMac Pro нь нэг террабайт багтаамжтай ба үнийн хувьд 4,999 ам.доллараас эхлэх болно. Харин 18 цөмийн процессортой загварууд нь дөрөв хүртэлх террабайт багтаамжтай байх аж. [ЗГМ]

АНХААРУУЛГА

Хөвсгөл нуураар зорчих эрсдэлтэй

Гол, нуурын ус гүйцэд хөлдөөгүй байгаа тул иргэдийг Хөвсгөл нуураар зорчихгүй байхыг аймгийн Мэргэжлийн хяналтын газраас мэдэгдлээ. Шинэ жилийн баяр болох гэж буйтай холбогдуулан иргэд ОХУ болон Ханх сумын чиглэлд ихээр зорчдог. Иймээс иргэдийг баталгаат зам болох Сантын даваагаар зорчихыг анхааруулаа.

Энэ жилийн хувьд олон жилийн дунджаас илүү дулаахан өвөл болж буй учраас Сантын даваа цаггүй, зорчих хэсэгт ямар нэгэн саадгүй байгаа аж. Тэнгис, Шишгэдийн голоос бусад гол мөрөн зөвхөн өнгөн хэсэгтээ хөлдөж, мөс нимгэн байгаа тул иргэд зам товчлох гэж эрсдэлд өртөхгүй байхыг анхааруулж байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	07.00 "Өглөө" хөтөлбөр	08:00 "Bloomberg Daybreak Asia"	08.05 "Монголчууд XX зууны эхэнд" нэвтрүүлэг	06.30 "Өнөө өглөө"
12.00	11.00 "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр	11:30 "Ногоон хот" нэвтрүүлэг	12.10 "Нууц материалууд" ОАК 2.16 дугаар анги	12.00 "Хөтөч" мэдээллийн хөтөлбөр
14.00	14.00 "Дотрын тасаг" ОАК 9, 10 дүгээр анги	14.00 "Өсөлтийн замд" нэвтрүүлэг	14:05 "Та 5 дугаар ангийн хүүхдээс ухаантай юу?" шоу нэвтрүүлэг	14.30 "Наашаа Цаашаа"
18.00	18.40 "Өвлөхүйн эрдэм" цуур урлаач Л.Дашжаргал	17.00 "Bloomberg Surveillance"	18.35 "Boney M Монголд"	18:00 "Тог тог тог" /season-6/ 18 дугаар анги
20.00	20.00 "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр	20.00 #Made in Mongolia: Дарханы төмөрлөгийн үйлдвэр ЖК	20.40 "Nous tech" танин мэдэхүйн нэвтрүүлэг	20.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
22.00	21.55 "Амьдрал бол гайхамшиг" УСК	22.00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	23:00 "Флаш" ОАК 2.20 дугаар анги	22.30 "Хавай 5-0" ОАК / season-7/ 24 дүгээр анги

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
2. Адуучны хэрэгсэл
3. Зуувгар хэлбэрээр
нь нэрлэсэн гурилан бүтээгдэхүүн
4. Эмэгчин бор гөрөөс

- Сансрын хөдөлгөөнт холбоо
- Засаг захиргааны нэгж
- Гутлын уланд болон адууны туурайнд бэхлэх зүйл
- Хөгжмийн зохиолч, хөгжмийн найруулагч, МУСТА Бат-Эрдэнийн хоч нэр
- Мадогнагийн дүрийг бүтээсэн, аргентиний домогт эмэгтэй дүр

ХӨНДЛӨНГӨӨР:

- Давсалж нөөцлөх мах
- Ховд аймгийн сум
- Оросын мэдээллийн агентлаг
- Энэ лугаа гэсэн үг
- Япон улсын төрийн тэргүүн
- Эм тэмээ
- ... анд минь

чи хаалгыг минь тогшооч


- Дэлгүүрийн сүлжээ
- Хойд, Өмнөд Америкийг заагласан суваг

Өмнөх дугаарын хариу / 12.19



ОНЦЛОХ ҮЗВЭР

"Цөмөөхэй ба Хулганы хаан"



Хүүхэд гэлтгүй хүн бүрийн хүсэн хүлээдэг П.И.Чайковскийн "Щелкунчик" балет энэ сарын 21-24-нд Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт болно. "Щелкунчик" балет нь анх 1892 оны арванхоёрдугаар сарын 18-нд Петербургийн Мариинский театрт үзэгчдийн хүртээл болж байжээ. Зохиолч Мариус Петипа Э.Т.А.Хоффманы "Цөмөөхэй ба Хулганы хаан" зохиолоос сэдэвлэн цомнолыг бичсэн аж. Тус зохиолыг барууны улсуудад 1940-өөд оноос тоглож эхэлсэн. Энэхүү балет нь Зул сарын баяраар хамгийн олон удаа тоглогддог оргил бүтээл юм. Америкийн томоохон балетын компаниуд жилийн орлогынхоо 40 хувийг "Цөмөөхэй"-гөөс олдог байна. Жүжгийн үйл явдал XVIII зууны сүүл үеийн Германы жижигхэн хотод Зул сарын баяраа тэмдэглэж буй нэгэн гэр бүлд өрнөдөг. "Щелкунчик" балет нь УДБЭТ-т 1982 онд анх тавигдаж байв. 90 минут үргэлжлэх тоглолтын тасалбарын үнэ 20-40 мянган төгрөг. [ЗГМ]

ҮЗВЭР

СҮХБААТАРЫН ТАЛБАЙ
Хамтлаг дуучид, уран бүтээлчдийн нийтэд зориулсан тоглолт энэ сарын 31-ний 21.00- 01.00 цагт Сүхбаатарын талбайд болно. Монгол Улсын төрийн шагналт найруулагч Н.Наранбаатар энэхүү арга хэмжээг найруулахаар болжээ. Н.Наранбаатар өмнө нь 2016, 2017 онд Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтын ажиллагааг найруулсан туршлагатай.

УЛААНБААТАР ЧУУЛГА
Улаанбаатар чуулгын "Дөрвөн өнгө" бүжгийн чуулбар тоглолт өнөөдөр 19.00 цагт болох гэж байна. Тив, дэлхийд ур чадвараа өндөрөөр үнэлүүлсэн чуулгын бүжигчдийн шилдэг тоглолт 80 минут үргэлжилнэ. Тасалбарын үнэ 15 мянган төгрөг.

EMBASSY
Зул сарын жааз үдэш энэ сарын 21-ний 19.00 цагт болно. Энэхүү үдэш дуучин Наагий, Солонго, Ub comedy Идэрээ болон бусад жааз дуучид урилгаар оролцоно. Тасалбарын үнэ 20 мянган төгрөг.

ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТР
Улсын хүүхэдэйн театрын уран бүтээлчид 70 жилийнхээ ойн баяраар "Гайхамшигт хайрцаг" гала тоглолтоо энэ сарын 29, 30-нд хүргэх гэж байна. Гала тоглолтод ОХУ-ын Хүүхэдэйн театрын "Үлгэр" театрын хамт олон оролцоно. Тус тоглолтод урилгаар гавьяат жүжигчин Л.Чимиддорж, Д.Гүрсэд, соёлын тэргүүний ажилтан Л.Долгор, А.Алимаа О.Норолхоо, Д.Эрдэнэчимэг, С.Балданпүрэв, Г.Пэрэнлэй Д.Алтанцэцэг нар залуу уран бүтээлчдийн хамтаар оролцохоор болжээ. Тасалбарын үнэ 25 мянган төгрөг бөгөөд хүүхэд бүрт бэлэгтэй.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 1


Өвлийн дунд хар хулгана сарын есөн улаан мэнгэтай цагаан луу өдөр
Үсзасуулбал: Насахар болно
Наран ургах, шингэх: 08.42-17.02
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй
Суудал: Ус

Аргын тооллын арванхоёрдугаар сарын 19, Ангарга гарга. Билгийн тооллын 1, Суулга одтой, цагаан луу өдөр.

Өдрийн наран 08.42 цагт мандан, 17.02 цагт жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүлшгүй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, ээтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, хур оруулах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болон. Хол газар яваар одогсон зүүн зүгт мөрөө гаргавал зохиистой. Балжинямтай өдөр. Үс шинээр үргэлжлэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	XII.19	XII.20	XII.21	XII.22	XII.23
	-9° -17°	-8° -18°	-10° -17°	-9° -19°	-12° -17°
Бага зэргийн цастай	6 м/с 8 м/с	7 м/с 5 м/с	7 м/с 5 м/с	5 м/с 6 м/с	5 м/с 6 м/с
	Бага зэргийн цастай	Үүл багасна	Үүлшинэ	Үүл багасна	Ялимгүй цастай



ЗГМ: КОМИКС



[ЗГМ СОНИН]

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" Сонины онлайм захиалга үргэлжилж байна.

"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ Сонины НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖИЛГАТАЙ ХОЛБООТой САНАЛ ХҮСЭЛТЭЭ

INFO@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ГАЛТЭРЭГИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Эрээн-УБ	18.00	11.15
Хөх хот-УБ	22.50	11.15
УБ-Хөх хот	20.00	20.49
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
Замын-Үүд-УБ	21.35	09.55
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Сүхбаатар	10.55	19.52
Сүхбаатар-УБ	06.30	15.35
Зүүнхараа-УБ	04.25	08.40

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	06.10	08.25
Бээжин-УБ	09.30	12.00
Сөүл-УБ	01.25	03.55
Сөүл-УБ	18.15	20.45
УБ-Сөүл	13.00	17.05
Токио-УБ	14.40	19.10
УБ-Токио	07.55	13.40
Ханбумбат-УБ	09.30	12.00
УБ-Ханбумбат	07.30	08.40

Тагнуулын мэдээ өгсөнд Д.Трампад талархав

ОХУ-ын Ерөнхийлөгч Петербург хотод террорист халдлага болж магадгүй талаар мэдээ өгсөнд талархал илэрхийлэв. > 10

Икеа-гийн татвараас зугтсан хэргийг шалгана

ЕХ татвараас зугтсан компаниудын эсрэг арга хэмжээний хүрээнд Шведийн Икеа компанид мөрдөн байцаалт эхлүүлээ. > 10

Tencent ба Alibaba-гийн гадаадад чиглэсэн өргөжилт

Хятадын Tencent хэмээх интернет групп хил дамнансан гүйлгээг хязгаарлах Засгийн газрын бодлогод хоригдсонгүй. > 10

1 Татвар буурснаар ирэх онд нэгж хувьцаанд ноогдох ашиг нь 18-19 хувиар өснө хэмээн Delta Air Lines компани тайлбарлаж байна. Хуулийн шинэчлэлээр хамгийн их ашиг олох компанийн нэг нь Уоррен Баффетын Berkshire Hathaway. Учир нь конгломератын бизнес АНУ-ын эдийн засагт төвлөрдөг. Татвар буурснаар тус компанийн орлого ирэх онд даруй 15 хувиар буюу 2.6 тэрбум ам.доллараар өсөх тооцоог хөрөнгө оруулалтын KBW банк гаргажээ. Татварын шинэчлэл хэр ашигтайг тайлбарлахаас цааргалсан компаниудын олонх нь хуулийн заалт тодорхой болоогүй байхад үр нөлөөг нь тооцоолох аргагүй хэмээн тайлбарлав. Сенат, Төлөөлөгчдийн танхим дахь бүгд найрамдахчууд хэлэлцэн тохиролцсоны дараа 503 хуудастай төслийг баасан гарагийн үдээс хойш нийтлэсэн. Компаниуд шинэ хуулийн төслийг ойлгохоор зөвлөхүүдийнхээ хамтаар бямба, ням гарагийг завгүй өнгөрөөлөө. Шинэ хууль нь татварын гажгийг илрүүлэх замаар “хэмхэрхий” тогтолцоог залруулж, хөдөлмөрлөгч айл өрхийн татварыг үлэмж нөнгөлөн хэмээн ноён Мнучин ням гарагт CNN-ээр тайлбарласан. Татварын шинэчлэл нь баячуудад барьж буй бэлэг



Ерөнхийлөгчийн шинэчлэл газрын тос боловсруулагч, банк, Buffet группад хамгийн ивээлтэй.

Трампын шинэчлэл зарим компанид илүү ээлтэй

гэсэн шүүмжийн хариуд сайд жишээ татлаа. Жилдээ 150 мянган ам.долларын орлоготой айл 4000, жилдээ 75 мянган ам.долларын орлоготой өрх 2000 ам.доллараар бага татвар төлнө гэдгийг ноён Мнучин дурдсан юм. Татварын хуулийг эцэслэн

батлахад “хэдхэн хоног үлдсэн”-ийг Дональд Трамп ням гарагт твиттертээ бичжээ. Долоо хоногийн эцэсээр хүчин төгөлдөр болох татварын шинэчлэл нь “дундаж ангийнханд барьж буй Зул сарын хамгийн том бэлэг” хэмээн АНУ-ын Ерөнхийлөгч тайлбарлаж байна.

Хуулийн төсөл энэ онд S&P 500 индексийг жилийн өмнөхөөс 18 хувиар өсгөж өгснийг зарим шинжээч өгүүллээ. Татвар буурснаар уг индексэд багтдаг компаниудын ашиг дунджаар 8-10 хувь өснө хэмээн Credit Suisse-ийн үнэт цаасны стратегич Жонатан Глоаб тооцоолов.

Дундаж ашгийг шинжээч нар өөр өөрөөр тооцжээ. Татварын шинэчлэл нь Delta Air Line-ийн 2018 оны нэгж хувьцаанд ноогдох ашгийг одоогийн тооцооноос нэг доллар орчмоор илүү өсгөнө хэмээн тус компанийн гүйцэтгэх захирал Эд Бастин хөрөнгө оруулагч нартаа

тайлбарласан. Тус компанийн одоогийн тооцоо нь 5.35-аас 5.70 ам.доллар байгаа юм. Ашиг нь үлэмж өсөх бусад компанид газрын тос боловсруулагч нар багтана. Valero Energy, Andeavor зэрэг тэргүүлэх үйлдвэрлэгчийн нэгж хувьцаанд ноогдох ашиг ирэх онд татварын шинэчлэлийн ачаар 15-32 хувиар өсөх тооцоог Simmons & Co-гийн шинжээч Ги Бэйбер гаргалаа. Vertical Research Partners-ын судалгааг үзвэл компанийн татвар 20 орчим хувиар багасах тохиолдолд United Technologies, Honeywell, Emerson Electric зэрэг тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн ашиг дунджаар 10 хувиар өснө. Татварын шинэчлэлээр банкууд ч үлэмж ашигтай ажилладаг болно. Төлөх татвар нь 20 хувиар буурах нөхцөлд JPMorgan Chase-ийн ашиг 20, Wells Fargo-гийнх 21 хувиар өсөх тооцоог KBW гаргажээ. АНУ-аас гадна байрладаг хөрөнгөд шинэ татвар оноож буйтай уялдан олон улсын хэмжээнд ажилладаг, үндсэндээ технологийн аварга компаниуд ирэх оноос илүү их татвар төлнө. Гэхдээ ийм компаниуд үнэт цаасаа буцаан худалдаж авах мөнгийг эх орондоо эргүүлэн авчрах замаар нэгж хувьцаанд ноогдох ашгаа өсгөх бололцоотой. **FT**

Уучлал хүсэх олиггүй арга

Эмма Жэйкобс
Энэ оны турш #MeToo буюу “Намайг ч бас” хөдөлгөөн өрнөлөө. Тэвчсээр ирсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гэс үсэрсэн уур хилэнгийн давалгаа Пахиурын хөндий, Холливуд, хэвлэл мэдээлэл, ресторан, улс төрийн салбарыг нөмрөв. Бэлгийн дарамт учруулсан тухай, өч төчнөөн түүх. Давалгааны араас буруутнууд гэм буруугаа хүлээсэн үг хөврүүлж гарав. Зохио шалгалтын дараа гэм буруутнуудын алдрын зам төгсгөл боллоо. Энэ 2017 он бэлгийн дарамт учруулагчид дуртай

хариу өгсөн эмэгтэйн өөдлөн дэвших замыг сүйтгэх нь байдаг л зүйл гэсэн бодолтой аваас ийм уучлалыг хүлээн авч болно. Хоёрдугаарт, зарим эмэгтэй энэ хүмүүсийн урхинд орсон байлаа ч энэ нь өөрийн дур хүслээр болсон үйлдэл биш. Харин ч эсрэг. Уучлалыг ч сонголт хийхэд ашиглаж болно. Бэлгийн дарамт учруулагсад, ялангуяа ажил мэргэжлийн ур чадвараараа бахархдаг дарамтлагсад бизнесийн ертөнц дэх үйл явдлын үй түмэн өрнөлийг гярхай ажиглах эрмэлзэлтэй хэвээр. Тэгсэн мөртөө тэд ажлын байранд бие авч явах соёл хувирсныг

шинээр хүндэтгэдэг болсон”-оо бичжээ. Энэ олон уучлал гуйлтаас нийтлэг илэрч буй зүйл бол нарциссизм буюу өөрийгөө эрхэмлэх явдал. Хүссэнээрээ дураараа дургих ёстой хүн нь би гэсэн бодол энэ хүмүүст бүгдэд нь бэрхшээл болдог. Өөрийг нь л анхаараач гэсэн утга бүхий уучлал хүссэн үг ярианд “Би” гэсэн үг хэчнээн удаа орж буйг тоолж үзлээ. Харви Вайнштейны 26 өгүүлбэрт 37, Чарли Роузын найман өгүүлбэрт 14, бэлгийн дарамт учруулсан хэрэгт буруутсан хошин жүжигчин Луи Си Кэйн 26 өгүүлбэрт 36 “Би” оржээ. Гарах ёстой байгаад хойшлогдсон Луи Си Кэйн шинэ киноны нэр хүртэл “БИ танд хайртай, Аав аа”. Алдар хүндтэй ямар ч од байхгүй жижигхэн компанид ажилладаг найзаасаа бэлгийн дарамтад өртсөн түүхийг нь яриууллаа. Сонины тэргүүн нүүрэнд гараад байдаггүй дарамт. Хамт ажиллагч нь өдөөн хатгасан захиаг ажлынх нь болон хувийн цахим шуудангийн хаягаар, хагас бүтэн сайнд мессежээр зогсоо зайгүй бөмбөгддөг, бага багаар ядаргаатай дарамтлагч нэгэн. Гэрэл зургийг нь нууцаар авч буйг бүсгүй үйлдэл дээр нь барьжээ. Хамт ажиллагсад нь дарамтлагчийн ариун өргөөний талаар тохуутай үг ажлын үеэр чулуудцаана. Тэсвэр алдсан бүсгүй хүний нөөцийн салбартаа хандахад болгоомжтой байхыг сануулаад өнгөрөв. Эцэст нь тэрбээр ажлаасаа гарсан юм. Дарамтлагч нь өөр хүүхдүүдийн араас мөн адил ангиучилсаар байгааг тэрбээр хэдэн сарын дараа хуучин ажил олгогчтойгоо санаандгүй таарах үеэрээ сонссон байна. Түүхийг нь сонсож дуусаад би түүнээс дарамтлагчийг өөрөөс нь уучлал гуйгаасай гэж боддог эсэхийг лавлав. Боддоггүй гэж байна. Дарамтлагчаас элдэв юм хангалттай сонссон тэрбээр өөрийг нь л сонсох хүн байгаасай гэсэн юм. **FT**



дургүй буруугаа хүлээсэн, олон алдартан айдас төрөм гэмээ наманчилсан жил болон өндөрлөх гэж байна. Ичгүүргүй хүсэлт, тэмтгээ, дайралтыг цайруулж чадахуйц өршөөл эрсэн үг гэж байдаггүйг энэ он харуулж өглөө. Харин уучлал хүсэх буруу ташаа арга зөндөө. Уучлах хүсэх даан ч олиггүй загварыг Харви Вайнштейн үзүүлэв. Гэмээ хүлээсэн түүний өчил буруугаа хаацайлсан тайлбартай. “Биеэ авч явах болон ажлын байрны талаарх бүх дүрэм журам өөр байсан 60, 70-аад онд би насанд хүрсэн. Тэр цагт соёл өөр байлаа” хэмээн мань эр өчлөө. Уг тайлбар нь үлэг гүрвэл аятай найдваргүй мөхөж буй эдгээр эрсийн биеэ хамгаалах оновчгүй бөгөөд нийтлэг байр суурь. Нэгдүгээрт, дээрх эрхмүүдийн насны бүх эрчүүд эрээгүй дайралтад татгалзсан

ажигладаггүй зориудын санаатай сохор хүмүүс. Ноён Вайнштейн уучлал гуйхдаа эмчилгээ хийлгэхээр амлахаа мартсангүй. Уучлал гуйсан бусад эрхэм ч түүний замаар замналаа. Илэрч баригдсан нь соён гэгээрэх замд хөл тавьж “өөрийгөө нээх аялал” болж хувирав. Бэлгийн дарамт учруулсан хэрэгт буруутгаж өнгөрсөн сард өчил буруугаа хаацайлсан тайлбартай. “Бусад нь ч бас сурах байх” хэмээн бичсэнээс нь үзэхэд мань хүн болж өнгөрсөн явдлыг бусдад юм зааж сургах бэлэг болгон хувиргажээ. Ноён Роуз “өөрийг минь оролцуулаад бид бүгдээрээ урьд өнгөрснөөс үүдэлтэй шаналлыг шинээр, илүү гүн ойлгож эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн амьдралыг доо



Калифорнийн түймэр даатгагчдад дарамт болж байна

Алистар Грей, Оливер Ральф
Даатгалын компаниуд өмнөд Калифорнид дэгдсэн ойн түймрийн улмаас дахиад л олон тэрбум ам.долларын алдагдал хүлээх гэж байна. Энэ он бол даатгалын салбар дахь хамгийн үрэлгэн жилийн нэг. Бүс нутагт шатаж буй олон түймрээс хамгийн ноцтой нь Вентура, Санта Барбара тойрогт дэгдсэн Томасын түймэр. Уг түймрээс үүдсэн хохирол бараг 1.5 тэрбум ам.доллар хүрээд байгааг Moody's Analytics-ын ахлах эдийн засагч Адам Каминс мэдэгдлээ. Түймэр хэр удаан үргэлжлэхээс шалтгаалан хохирлын хэмжээ цаашид ихэснэ. Үүний зэрэгцээ салхи хаашаа чиглэхээс түймэр үргэлжлэх хугацаа хамаарах юм. Даатгалын компаниуд энэ онд тохиолдсон байгалийн гамшгаас үүдэлтэй 100 гаруй тэрбум ам.долларын даатгал олгох ёстой. Гамшигт Калифорни тэнгис, АНУ-ын өмнөд эрэг орчмыг хамарсан хар салхи, Мексик дахь газар хөдлөлт, аравдугаар сард умард Калифорнид дэгдсэн түймэр багтаж байна. Сүүлд дэгдсэн түймэр өнгөрсөн бямба, ням гарагт улам ихэслээ. Гал түймэртэй тэмцэх алба Лос-Анжелесээс умар зүгт орших Санта Барбара хотын зарим хэсэг, зэргэлдээх Монтезитийн оршин суугчдыг бүхэлд нь нүүлгэх тушаал өгчээ.

Монтесито бол Опра Уинфри, Эллен ДеЖенерес зэрэг нэр алдартны төрөлх хот. Лос-Анжелесийн хойно орших Бел-Эйр дахь олон тэрбумын үнэтэй орон сууцнуудыг оролцуулаад үлэмж хэмжээний хөрөнгө шатав. Даатгалын компаниуд үнээ өсгөх замаар алдагдлаа нөхөхөөр оролдож буйтай уялдан галд өртөж болзошгүй бүсийн хөрөнгө чинээ багатай хэсгийнхэн ч эрсдэлтэй тулгарлаа. Гамшигийн хохирол аварга байгаа тул даатгал сунгуулах үе эхэлдэг нэгдүгээр сарын 1-нээс үнэ нь лавтай өсөж таарна. Сунгуулах үнэ өсөх хэрээр хувь хүмүүс, бизнесийнхэн худалдан авдаг анхдагч даатгалын төлбөр өөрчлөгдөх тул даатгалын үнэ нийтдээ өснө хэмээн зарим нь үзэж байна. “Өмнөд Калифорнид хуурай халуун шатаж, хүн төвлөрсөн хэсэгт ойр газарт олон түймэр үүсэн, тогтмол нэг зүгт үлээдэг Санта Ана салхи салхилж байгаа нь даатгалын компаниуд их хэмжээний алдагдал хүлээх нөхцөл бүрдүүлээ” хэмээн AIR Worldwide загварчлалын агентлагийн менежер, эрдэмтэн Томас Гирниус тайлбарлав. Тэрбээр түймрийн улмаас 18 мянган үл хөдлөх хөрөнгө гэмтэх, бүрэн шатах аюултай тулгараад буйг Калифорнийн эрх баригчдад анхааруулжээ. Одоогоор 1230 барилга байгууламж түймэр

өртөөд байна. Аравдугаар сард Калифорнийн Умард тохойг хамарсан галан шуургаанд 15 мянган барилга байгууламж өртөж даатгалын компаниудад 9.4 тэрбум ам.долларын хохирол учирсан. “Түймэрт өртөж буй байшин барилга ихэвчлэн чинээлэг хэсгийнхэн амьдардаг бүсэд байрлах байгаа”-г ноён Каминс тайлбарлав. Хар салхины улмаас үүссэн үер зэрэг өөр гамшгаас үүдэлтэй хохирлоос ялгаатай нь түймрийн хохирлын дийлэнхийг даатгалын компани нөхөн төлнө. Сүүлийн гамшгаас учирсан хохирлын мэдүүлэг боловсруулах ажлыг хурдасгахыг Калифорнийн даатгалын комиссар Дэйв Жонс даатгалын компаниудад уриалав. Даатгуулагчийн баримт бичиг түймэрт шатсан байх магадлал их учраас баримт бүрдүүлэхэд уян хатан хандахыг тэрбээр анхааруулсан юм. “Аравдугаар сард дэгдсэн умард Калифорнийн түймэртэй харьцуулахад сүйдэж, гэмтсэн үл хөдлөх хөрөнгө харьцангуй цөөн ч хохирол нь илүү гарах төлөвтэй. Даатгагчдын хувьд хэдэн жил үргэлжилж буй их хохирол дээр дахиад нэг гарз нэмэгдэж буй хэрэг” хэмээн TigerRisk даатгалын компанийн түнш Майк Шнур өгүүллээ. **FT**

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Tencent ба Alibaba-гийн гадаадад чиглэсэн өргөжилт

Люьс Лукас

Snap, Tesla, Spotify зэрэг компаниуд хувьцаа эзэмшдэг Хятадын Tencent хэмээх интернет групп хил дамнан гүйлгээг хязгаарлах Засгийн газрынхаа бодлогод хоригдохгүй байна. Тус компани энэ сарын эхээр Шведийн Spotify стриминг үйлчилгээг хувьцаа худалдан авахаар шийдвэрлэсэнээр Шенженд төвтэй группын гадаад эзэмшил 4.3 тэрбум ам.долларт хүрч, гаднын 15 компанийг хамарлаа гэж Dealogic фирм мэдээлэв. Үүнийн дотор АНУ-ын технологийн томоохон хоёр компани дахь эзэмшил нь дээгүүр байр эзэлдэг. Тус групп Snapchat апп-ын эцэг Snap компанийн 10 хувь, цахилгаан машины үйлдвэрлэгч Tesla-гийн таван хувийг эзэмшдэг ба бусад жижиг эзэмшлийг оруулаагүй гэж дээрх мэдээнд дурджээ. Эднийх дотоод худалдан авалтад 20.5 тэрбум ам.доллар зарцуулсан байна.

Tencent-тэй ижил түвшний Alibaba цахим арилжааны групп энэ онд 2.4 тэрбум ам.долларын өртөгтэй хил дамнан найман хэлцэл хийснийг Dealogic мэдээллээ. Эднийх өнгөрсөн онд гадаад худалдан авалтад дотоодлоо дэлгүүрүүд барих, логистикийн сүлжээ байгуулахад голлон анхаарсан. Бээжин HNA, Dalian Wanda, Apbang, Fosun зэрэг томоохон бизнесүүдийн гадаад худалдан авалтыг хязгаарласан хэдий ч технологийн хоёр аварга компани ийнхүү гадаад эзэмшлээ зузаатгав.

хэлхгүй” хэмээн тайлбарлав. Alibaba арай өөр хандлагатай. Эднийх Зүүн өмнөд Азид төвлөрч, хувьцааны ихэнхийг авах сонирхолтой байдаг. Жишээ нь, Сингапурт төвтэй цахим арилжааны Lazada компанийн 83 хувийг худалдан авчээ. Үүний зорилго нь Alibaba-гийн загварыг шинэ зах зээлд гаргах явдал. Компанийг үндэслэгч бөгөөд цуцашгүй ерөнхий захирал Жак Ма хил хязгааргүй худалдаа, цаасан мөнгөгүй нийгмийн үзлээ түгээхээр энэ онд 1000 орчим цагийг онгоцонд өнгөрөөв. Бээжингийн хязгаарлалтаас гадна АНУ-ын засаг захиргаа үндэсний аюулгүй байдал гэдэг шалтгаанаар Хятадын худалдан авалтыг эсэргүүцэх болсон.

Гэхдээ технологийн хоёр аваргын хувьд оддын тохироо бүрдсэн бололтой. Нэг хөрөнгө оруулагч “Энэ хоёр компанийн Хятадад хийж буй инновацийг өндөр тушаалтнаас эхлээд гудамжинд тааралдсан хүмүүс магтаж, үндэсний бахархал гэж боддог” хэмээн өгүүлэв. Бизнесээ урагшлуулахыг хүсэж байгаа бол намын шугамыг дагах ёстой агаад хоёр Ма Бээжинтэй хэл амаа ололцох тал дээр гаргууд хүмүүс. Tencent-ийг үндэслэгч Пони Ма Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын гишүүн. Alibaba-г үндэслэгч Жак Ма хагас дипломат маягийн үүрэг хүлээж, өөрийн брэндийн зөөлөн хүчийг Австрали, Аргентин, АНУ-д хүртэл түгээж, нэр дөвшигч Дональд Трамптай уулзаж байв. Хоёр Ма Бээжингийн шинэ санаачилга, удирдамжийг маш түргэн тусгаж



В.Путин тагнуулын мэдээ өгсөнд Д.Трампад талархав



Катрина Мансон

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин ням гарагт АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамптай утсаар ярьж, Петербург хотод террорист халдлага болж магадгүй талаар Тагнуулын төв газрын мэдээ өгч анхааруулсанд талархал илэрхийлэв. Кремлийн мэдэгдсэнээр өмнө нь ТТГ Петербургийн Казаны сүм болон бусад газарт дэлбэрэлт хийх гэж буй талаар мэдээ өгсний дагуу алян хядагчдыг баривчилсан байна. “ТТГ-аас ирүүлсэн мэдээ гэмт хэрэгтнүүдийг баривчлахад хангалттай байсан” гэж энд дурджээ.

Цагаан ордон утсаар ярьсныг нотолсон мэдэгдэлдээ “АНУ-ын өгсөн мэдээлэлд тулгуурлан Оросын албад олон хүний аминд хүрч болзошгүй байсан халдлагыг таслан зогсоож, алян хядагчдыг баривчилсан төдийгүй ноён Трамп Оросын талаас

талархал илэрхийлж ярьсныг өндөр үнэлсэн” гэжээ. Цааш нь “Хоёр удирдагч улс орнууд хамтран ажиллалал зөв зүйлд хүргэх жишээ болсон гэдэгт санал нийлсэн” хэмээн дурдав. Тагнуулын албатайгаа маргаантай байсан ноён Трамп мөн ТТГ-ын захирал Майк Помпеод утсаар, баяр хүргээд “Тагнуулын албад бүгдээр сайн ажиллалаа” хэмээн үнэлсэн байна.

Хоёр улсын тагнуулын албад хамтран ажилласныг ийнхүү нийтэд зарласан нь ноён Путини “тагнуулын хийрхэл” нэрлэсэн үргүй зөрчилдөөнийг таслах оролдлого юм. Путины үг 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Москва гаднаас санаатайгаар оролцож, арчиал, хууль эрхийг гажуудуулахыг оролдсон эсэх талаар маргааныг хэлсэн хэрэг. Дөрвөн өдрийн дотор хоёр удирдагч хоёр дахь удаагаа утсаар ярих үеэр ноён

Путин АНУ ба тус улсын иргэдэд учирч болох террорист аюулын талаар ОХУ-ын тагнуулын албад ирсэн мэдээг шилжүүлэн өгөхөө амласан гэж Кремлийн хэвлэлийн алба тэмдэглэв.

2016 оны сонгуульд Трампыг ялуулах оролдлого, Сири, Украин, Афганистан, Хойд Солонгосын асуудлаар зөрчлийн улмаас хоёр улсын харилцаа түүхэн доод түвшинд хүрснийг Америкийн албаныхан ярьдаг. Хоёр тал энэ онд тус тусын дипломатуудыг албадан гаргасны дээр Обамагийн захиргаа ба конгрессоос Оросын эсрэг хориг арга хэмжээ аваад буй. Ноён Трамп Кремлийг хорихорхон шүүмжилдэг агаад харин ч Холбооны мөрдөх товчооны дарга асан Роберт Мюллерийн удирдлага дор явуулж буй Оросын улс төрийн оролцолыг талаар мөрдөн байцаалтыг “шулмын ангуучлал” хэмээн тохуурхад хоёр талын харилцаа сайжирна

гэдэгт найдаж буйгаа удаа дараа илэрхийлсэн билээ.


Гэвч АНУ-ын үндэсний аюулгүй байдлын зөвлөх МкМастер Оросыг АНУ-ын гол аюулын нэг гэж мэдэгдсэн. Тэрбээр “Бид Оросын зүгээс шинэ үеийн дайны байдал гэх зэрэг аюултай тулгарч байна. Энэхүү нарийн түвэгтэй тэмцэл нь цахим хэрэгсэл ашиглан олон эх үүсвэрээс хорлон сүйтгэх, худал мэдээлэх, ухуулга хийх зэргийг агуулдаг” гэсэн юм. Оросын албаныхан Москва ба өрнөдийн хооронд харилцаа тасалдсан нь терроризм, Сирийн дайн зэрэг нийтийн аюул заналын асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллахад саад хийж байна гэж үздэг.

Кремлийн өндөр тушаалын хүн өнгөрсөн долоо хоногт “Та нар бэлэн бол бид бэлэн гэж хэлдэг. Солонгосыг ярилцах бол шууд хэл. Сирийн талаар ярилцъя. Терроризмын эсрэг хамтран ажиллах бол тэгье гэдэг” хэмээсэн байна. Оросын Холбооны аюулгүй байдлын алба дэлбэрэлт зохион байгуулах, гар аргаар тэрхүү бодис үйлдвэрлэх долоон хүрн оролцсон ажиллагааг таслан зогсоосноо баасан гарагт зарласны дараа хоёр Ерөнхийлөгч утсаар ярьсан юм. Тус албаанаас гаргасан мэдээлэлд бямба гарагт дэлбэрэлт хийхээр товчлосон агаад уг халдлагыг Исламын улс террорист бүлэгтэй холбоотой хүмүүс төлөвлөж, гадаадаас сүлжээгээр удирдаж байсан гэж онцлов.



ХЯТАДЫН ГАДААД ДАХЬ ХУДАЛДАН АВАЛТ

Хятадын компаниуд гадаад хөрөнгө худалдан авах нь эрс нэмэгдсэн
(тэрбум ам.доллар)



Snap-тай хоршсоноор Tencent мэдээ түгээлт, мобайл тоглоом зэрэгт хамтрах боломж нээгдэж байна. Түүнчлэн Tesla болон дотоодын цахилгаан машин үйлдвэрлэгч Nio-той хамтрах нь Tencent-эд туршлага багатай салбарыг ажиглах, сурах боломж олгох юм. Тус групп дээрх харилцаа интернетэд холбогдсон машин бүтээх болон үйлчилгээ нь машинд хэрхэн ажиллахыг туршихад тус болно гэж мэдэгджээ. Энэ үзэл санаа гадаадад өргөжихийг эрмэлзэж буй Tencent, Alibaba хоёрын аль алинд нь маш өвөрмөц, хамгаалалт ихтэй салбарт чухал туршлага болох юм. McKinsey зөвлөх фирмийн шинжээч Ананд Свамианатан “Гэд сурахыг эрмэлзэж байна. Энэ бол хоёр урсгалтай зам. Аль ч худалдан авагч бий юмыг сурахын тулд Uber хөрөнгө оруулсан гэж

авдаг. Одоо энэ нь Ази, Европын 64 улсыг холбох “Нэг бүс, нэг зам” төсөлд оролцох явдал юм. Түүнчлэн Alibaba энэ сарын эхээр хөдөөгийн ядууралтай тэмцэх хөтөлбөрт 1.5 тэрбум ам.доллар гаргахаа зарласан нь Бээжингийн бодлогод мөн л нийцж буй.

Alibaba, Tencent хоёрт Хятадын хэрэглэгчдийн талаар, тэдний зарцуулалт, найз нөхөд, унших дуртай зүйл, нүүр царайных талаар хүртэл асар их мэдээлэл буй. Гэхдээ саад тотгор ч байгаа. Тухайлбал, Tencent-ийн Tencent of Kings тоглоом хүүхдийн цагийг хэт их авч байгаа тул зохицуулагчдын дургүй хүргэв. Түүнчлэн технологийн зарим компани зүй бус постуудыг хянаж чадаагүй учир хариуцлага хүлээсэн байна.



Ikea-гийн татвараас зугтсан хэргийг шалгана

Рошелл Топленски

Европын холбоо татвараас зугтсан компаниудын эсрэг хатуу арга хэмжээний хүрээнд Шведийн Ikea компанийн талаар даваа гарагаас мөрдөн байцаалт эхлүүлэв. ЕХ-ны өрсөлдөөний комиссын тэргүүн Маргрет Вестигер тус компани Голландын талтай хуйвалдаж, 2009-2014 оны хооронд ЕХ-ны нэг тэрбум еврогийн татвараас зайлсхийсэн гэх хэргийг мөрдөх ажлыг даваа гарагт албан ёсоор эхлүүлсэнэ зарлав. Уг хэрэг Европын парламентад дахь Ногоон намынхны 2016 онд нийтлүүлсэн тайланд суурилсан байна. Ikea Голланд, Люксембург, Лихтенштейн улсуудад тусдаа хоёр салбар байгуулсан татварын журмын доорхойг ашиглаж, мөнгө ба ашгаа эргүүлж байсан аж.

ЕХ-ны өрсөлдөөний алба Голландтай хийсэн гэрээ холбооны журмыг зөрчсөн эсэхийг тогтоосны дараа татвараас зугтсан хэмжээг тодорхойлоно. 2013 оноос хойш Европын улс дамнасан корпорациудын хооронд байгуулсан мянга гаруй гэрээг шалгажээ. Таван хэрэгт мөрдөн байцаалтын дүгнэлт гарсан нь таван улс ба Apple, Starbucks, Fiat, Amazon зэрэг дөчөөд компаниуд хамаарах



агаад хэдэн тэрбум еврог буцаан төлөх үүрэг өгсөн юм. Хатагтай Вестигер “Олонх тохиолдолд давуу эрх өгөөгүй. Цөөн компани л татварын хөнгөлөлт эдэлсэн. Манай мөрдлөг дуусаагүй байгаа. Гэхдээ улсаас дэмжлэг авсан гэх шинж тэмдэг илэрсэн газар бүрд шалгалт хийнэ” хэмээн мэдэгдсэн. Ikea улсын компани биш тул мэдээлэл хомс бөгөөд улс дамнасан олон компаниудын адил олон оронд салбартай. Жижиглэн худалдааны Ikea групп наймдугаар сард төгссөн санхүүгийн жилд татварын өмнөх ашиг 3.31 тэрбум еврогоос татварт 825 саяыг төлсөн байна. Брэндийн нэр ба үзэл санааг эзэмшдэг Inter Ikea салбар

нь 1.15 тэрбум еврогийн татварын өмнөх орлогоос 241 саяын татвар өгсөн байна. 2016 онд Вестигер Apple компани Ирландтай гэрээ хийж, татвараас зугтсан гэж үзсэн тул 13 тэрбум еврогийн татварын буцаан төлөлт хийхийг шаардсан шийдвэр гаргасан нь АНУ-тай харилцаа хурцдахад хүргэж байв. Түүнчлэн Голландын Starbucks-тай хийсэн хэлцэл, Люксембургийн Fiat, Amazon-той байгуулсан тохиролцоог буруушаасан шийдвэр гарсан билээ. Үүнээс гадна Бельгийн Засгийн газраас хөнгөлөлт авсан 35 компанийг 700 орчим сая евро буцаан төлөхийг шаардсан байна. Улс орнууд болон олонх

компани ЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн зарга мэдүүлсэн. Гэвч Европын холбоо татвараас зайлсхийхтэй тэмцэх хүчин чармайлтаа үргэлжлүүлсээр буй. Энэ хүрээнд компанийн тайланг ил тод болгох, татварын цоорхойг бөглөх, оффшорын хар жагсаалт гаргах болон ЕХ-нд татварын өргөн шинэчлэл явуулах арга хэмжээ авч байна.

Зарим улс шинэчлэл хийхээс өмнө дижитал компаниудад тусгай татвар ногдуулах арга хэмжээ санаачилжээ. ЕХ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагагай хамтран татвараас зугтахын тулд улс орнуудын хооронд ашгаа зохиомлоор шилжүүлдэг практикийг зогсоох оролдлого хийж буй. АНУ-ын засаг захиргаа мөн Америкт төвтэй улс дамнасан компаниудын ашгийг эх оронд нь авчрахын тулд компанийн татварыг бараг 15 хувиар бууруулах хуулийн төсөл хэлэлцэж байгаа. Татвараас зугтахын эсрэг тэмцэл газар сайгүй явагдаж байгаа ч АНУ-ын томоохон компаниуд 1.4 их наяд орчим ам.долларыг оффшорт хадгалдаг гэж Moody’s агентлаг мэдээлсэн. Ikea компани болон Европын комисс дээрх асуудлаар тайлбар өгөхөөс татгалзлаа.



Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Хялбаршуулсан татварын ТОГТЛОЦОО НЭВТРҮҮЛНЭ

Эдийн засгийн өсөлтийг чанаржуулж, бэхжүүлэх нь чухал

Б.Мөнх
ЗГМ

ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сайкертай цөөн хорм ярилцлаа. Тус сангийн Захирлуудын зөвлөл Монгол Улсад хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хоёр шатны үнэлгээг хянаж, 79.1 сая ам.долларын санхүүжилт баталсантай холбогдуулан тэрбээр сэтгүүлдэд мэдээлэл хийсэн юм.



Б.Ганбаяр / ЗГМ©

-Монгол Улсын Засгийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа вэ?

-ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Монгол Улсад хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн нэг болон хоёрдугаар шатны үнэлгээг хянаж, 79.1 сая ам.долларын санхүүжилтийг баталлаа. Бодлогын хэрэгжилт тууштай, гадаад орчин тааламжтай байсны ачаар эрх баригчид хөтөлбөрийн хүрээнд тавьсан бүх зорилтот тоон үзүүлэлтүүдийг давуулан биелүүлж чадсан. Ингэснээр эдийн засагт эерэг төлөв давамгайлж эхэллээ. Өөрөөр хэлбэл, Монголын эдийн засаг тооцоолж байснаас богино хугацаанд хурдан сэргэж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт сайн байлаа.

-Хөтөлбөрийн зорилго эхнээсээ биелэлээ олоод эхэлсэн гэж үзэж болох уу?

-Монгол Улсын Засгийн газар, ОУВС энэ оны тавдугаар сард 36 сарын хугацаатай хөтөлбөр хамтран хэрэгжүүлэхээр болсон. Хөтөлбөрийн хүрээнд 425 сая ам.долларын санхүүжилт олгогдохоор байгаа. Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилт бол Засгийн газраас өргөн дэвшүүлсэн "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг дэмжих явдал байсан. Үүний дотор эдийн засгийг тогтворжуулах, төлбөрийн тэнцлэл үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах, улмаар төсвийн өндөр алдагдлыг бууруулахад чиглэж байгаа.

Цаашилбал, эдийн засаг дунд хугацаанд тогтвортой өсөх хөрс суурь бүрдүүлэхээр зорьж байна.

Монголын эдийн засаг тооцоолж байснаас богино хугацаанд хурдан сэргэж байна

-Энэ он болон ирэх оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг хэрхэн таамаглаж байгаа вэ. Урьдын тооцоололд өөрчлөлт гарсан уу?

-Хөтөлбөр хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн байна. Энэ хооронд эдийн засагт нэлээд дорвитой өөрчлөлтүүд гарлаа. Юуны өмнө эдийн засаг тогтворжиж чадлаа. ДНБ-ий өсөлт таамаглаж байснаас хавьгүй өндөр гарч байна. Эдийн засгийн өсөлт хурдан хурцанд бий боллоо. Энэ оны хувьд ДНБ-ий өсөлт 3.3 хувьд хүрэх төлөвтэй байгаа. Харин ирэх онд 4.5 хувьд хүрч өсөх төсөөлөлт бий. Эдийн засгийн өсөлтөд бидний таамаглал нэлээд болгоомжтой хандсан. Монголын хувьд бодлогын нөлөө богино хугацаанд харагдаж эхэлж байна. Үүнд мөнгөний зохистой бодлого хэрэгжүүлсэн нь эерэг нөлөө үзүүлсэн. Цаашид эдийн засгийн өсөлтийг чанаржуулж,

бэхжүүлэх нь чухал.

-Эдийн засаг энэ оны гуравдугаар улирлын байдлаар 5.8 хувиар өсөдөг байна. ДНБ-ий өсөлт ийнхүү өндөр гарахад юу хамгийн их нөлөөлж байна вэ?

-Гадаад орчны тааламжтай байдал голлох нөлөө үзүүлж байна. Ялангуяа, БНХАУ-ын нүүрсний эрэлт өндөр байснаар өсөлтийг улам дэмжлээ. Дан ганц зах зээлийн нөхцөл байдлаас гадна Монголын эдийн засагт итгэх хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, бизнесийн орчинд энэ нь тусгалаа олж байна. Төгрөгийн ханшийн уналт тогтворжиж, Монгол руу чиглэсэн хөрөнгийн урсгал нэмэгдлээ. Үүнд хувийн хэвшлийг чиглэсэн хөрөнгө оруулалтаас гадна хандивлагч орнуудын өгч байлалтын дэмжлэг давхар нөлөөлж байна. Мөн олон улсын зах зээл дэх Монголоор овоглосон бондын хүүгийн түвшин эрс буурлаа. Засгийн газрын дотоодод гаргасан бондын хүү 18 хувиас 11 болтлоо буурч, тэр хэрээр зардал буурч байна. Өнгөрсөн хугацаанд гадаад валютын албан нөөц эрчимтэй өсөж, 2.5 тэрбум ам.доллар хүрч, цаашид өсөх төлөвт шилжлээ.

-Төсөвт онцлох өөрчлөлт гарч чадсан уу?

-Төсвийн бодлогын хүрээнд нааштай өөрчлөлт гарсан. Тодруулбал, төсвийн алдагдал хоёр дахин буурч, ДНБ-ий 7.5 хувьтай тэнцлээ. Хөтөлбөрийн хэрэгжилт 2021 оны үеэр

дуусах үед үр ашигтай байх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Төсвийн алдагдлыг бууруулах хүрээнд Засгийн газар тодорхой алхмууд хийсэн. Нөгөө талдаа, төсвийн орлого нэмэгдүүлэхээр тодорхой арга хэмжээ авсан. Үүний нэг нь, татварын орчны зохицуулалт байсан.

- ДНБ-ий өсөлт таамаглаж байснаас хавьгүй өндөр гарч байна. Эдийн засгийн өсөлт хурдан хугацаанд бий боллоо.
- Монголын хувьд бодлогын нөлөө богино хугацаанд харагдаж эхэллээ.
- Хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, бизнесийн орчинд энэ нь тусгалаа олж байна.

-Гурван жилийн хугацаатай хэрэгжих хөтөлбөрийн хүрээнд татварын хувь, хэмжээ энэ оноос нэмэгдэж эхэлсэн. Ирэх оноос Хувь хүний орлогын татвар нэмэгдсэн хувилбараар хэрэгжинэ. Үүний цаана инфляц өсөх, иргэдийн амьжиргаа муудах сөрөг үр дагаварыг хэрхэн тооцоолсон бэ. Татварын нэмэгдэл нь эдийн засаг тогтвортой өсөх боломжийг хаах юм биш биз?

-ОУВС-гаас өсөн нэмэгдэх татварын тогтолцоог дэмжиж ирсэн. Гол зарчим нь өндөр орлого олж байгаа иргэдээ өндөр татвар авахад чиглэсэн. Татварын шатлал бий болгож байгаа. Орлого нь шатлалаас хамаарч, татварын хувь, хэмжээ шалтгаална. Татварын орчинд томоохон шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа. Энэ шинэчлэлийн гол зорилго нь тэгш байдлыг дэмжих төдийгүй эдийн засгийн өсөлтийг тэтгэхэд чиглэнэ. Үүн дээр ОУВС-гийн олон зөвлөх ажиллаж байна. Хялбаршуулсан татварын тогтолцоо нэвтрүүлнэ.

-Хөтөлбөрийн дараагийн шатны үнэлгээний баг хэзээ ирэх вэ?

-Дараагийн үнэлгээний баг удахгүй буюу ирэх оны нэгдүгээр сарын сүүлчээр ирнэ. Хөтөлбөрийн үнэлгээ улирал тутам хийгдэж байгаа. Гурван сар тутам Ажлын хэсэг Монголд ажиллана гэсэн үг. Захирлуудын зөвлөлийн хурлаас дараагийн бэлтгэл ажилд шилжиж байна. [ЗГМ]

ТАЙЛАН Монголын дэд бүтэц маш муу хөгжсөн гэв

АНУ-д төвтэй "Mining Journal" дэлхийн эрсдэлийн 2017 оны тайландаа Монголын дэд бүтцийг "маш муу хөгжсөн, эрсдэл өндөр" гэж дүгнэжээ. Тайланд уул уурхайн томоохон 85 бүс, хуулийн этгээдийг 3600 үзүүлэлтээр шинжиж, хөрөнгө оруулалтын эрсдэлийг 1-100 оноогоор үнэлсэн байна. Канадын таван муж, АНУ-ын Аляска, Швед улс 80-аас дээш оноо авч "ААА" буюу хамгийн бага эрсдэлтэй гэсэн үнэлгээ авчээ. Харин Лаос болон Гвиней 40-өөс доош оноо авч "DDD" буюу хамгийн эрсдэлтэй. Харин Монгол 53 оноо буюу "ССС" үнэлгээгээр "өндөр эрсдэлтэй" оронд тооцогдож байна.

Монголын эрх зүйн орчныг 49, засаглалыг 64, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг 66, санхүүгийн орчныг 52 оноогоор үнэлжээ. Харин дэд бүтцийг 11 оноогоор үнэлж хамгийн сул хөгжсөн болохыг онцолжээ. Задлал харвал төмөр зам долоо, эрчим хүчний баталгаа 15 оноогоор үнэлэгдэж байна.

хөдөө аж ахуй

Уламжлалт салбарын экспорт 1.1 тэрбум ам.долларт хүрчээ

Ж.Жаргалмаа
Шинжээч

Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний экспорт энэ онд 1.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс махны экспорт хамгийн өндөр өсөлттэй байлаа. Тодруулбал, энэ онд нийт 24 мянган тонн мах экспортсон нь жилийн дүнгээр 2.2 дахин өссөн үзүүлэлт юм. Ингэснээр нийт дүн нь 108 тэрбум төгрөгт хүрчээ. Махны экспорт нэмэгдэхэд шинэ үйлдвэрүүд байгуулагдсан нь нөлөөлсөн гэж шинжээчид үзэж байна. Энэ онд "Мах маркет" компани экспортын шинэ үйлдвэрээ нээсэн. Мөн "Кинг Мийт" компани гурван тэрбум төгрөгийн өртөгтэй ангилсан махны үйлдвэрээ ашиглалтад оруулсан юм. Экспортсон нийт мах, махан бүтээгдэхүүний 90 хувийг адууны мах эзэлж байна. Шүлхийн тархалтын улмаас хонь, үхрийн махны экспорт төлөвлөсөн хэмжээнээс бага байлаа. Салаа туурайт малын мах ихээр импортолдог БНХАУ л гэхэд есдүгээр сараас эхлэн адуунаас бусад малын махыг түүхийгээр авахаа зогсоосон юм. Ноос, ноолууран бүтээгдэхүүн



ВВМ80

экспортолдог компаниудын орлого энэ онд дунджаар 28 хувиар өссөн дүнтэй байгааг Ноос, ноолуурын холбоо мэдээллээ. Энэ онд 800 орчим тэрбум төгрөгийн самнасан ноолуур боловсруулсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 160 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм. Үүний 70 орчим хувийг экспорттоод гаргасан байна. Ноолуурыг ангиулж үзвэл, самнасан ноолуурын экспортын хэмжээ 9400 тонн хүрч өнгөрсөн оныхоос 35 хувиар өсчээ. Харин

сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл найман хувиар өсөж, 25.8 сая ам.долларын нэхмэл бүтээгдэхүүн экспортод гаргасан байна. Энэхүү өсөлтөд сүүлийн нэг жилд шинээр нээгдсэн 20 орчим ноос, ноолуурын үйлдвэр нөлөөлжээ. Тайлант хугацаанд ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлсэн шинэ төслүүдээс дурдвал "Говь" компани хилийн чанадад зургаан салбар дэлгүүрээ нэмж нэмсэн.

Мөн 2016 онд нийт борлуулсан пальтоныхоо 40 хувийг

экспортолсон бол энэ онд 80 хувь болгон нэмэгдүүлээд байна. Үүнээс гадна энэ онд хуурайшилт ихтэй зун болсон нь ургацын хэмжээ өнгөрсөн оныхоос 50 хувиар буурахад нөлөөлсөн юм. Ингэснээр шаардлагатай 225 мянган тонн улаанбуудайг ОХУ-аас импортлохоор болсон. Гэхдээ гурилын үнийг нэмэгдүүлэхгүйн тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг импортын гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг баталсан билээ.

ЗГМ ТОВЧХОН

» БАНК, САНХҮҮ

2.5

Тэрбум төгрөг. Банк бус санхүүгийн байгууллагууд хувь нийлүүлсэн хөрөнгөө ирэх оны хоёрдугаар сарын 10-ны дотор нэмэгдүүлэхээр болов. Хөрөнгийн хэмжээг зах зээлийн бүтэц, нөхцөл байдалтай уялдуулан Улаанбаатар хотод 2.5 тэрбум төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 600 сая төгрөг, бусад аймаг, сумдад 200 сая төгрөг байхаар ялгавартай тогтоосон. Үүнийг 2017-2021 он хүртэл дөрвөн жилийн хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг СЗХ-ноос батлан мөрдүүлж байна.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

"Даваабулаг" хувьцаат компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг Монголын хөрөнгийн биржээс мэдэгдлээ.

» УУЛ УУРХАЙ

2.12

Тэрбум ам.доллар. Эрдсийн экспортыг орлогын дүнгээрээ нүүрсний экспорт тэргүүлж, тайлант хугацаанд биет жингээр анх удаа улсын хэмжээнд 31.9 сая тонн хүрч, орлого нь 2.12 тэрбум ам.доллартай тэнцээд байна.

» ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос кастодиан банкны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Худалдаа хөгжлийн банк болон Хаан, Голомтын үнэт цаасны зах зээлд тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгов.

» МОНГОЛБАНК

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль ирэх оноос хэрэгжиж эхэлнэ. Үүнтэй холбоотойгоор "Цахим мөнгөний журам"-ын шинээр боловсруулсан төсөлд Монголбанк олон нийтээс санал авч байна.

» ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

275.9

Сая ам.доллар. Төлбөрийн тэнцэл энэ оны гуравдугаар улирлын байдлаар 275.9 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 462.1 сая ам.доллараар нэмэгджээ.

» СТАТИСТИК

2:4

Сая хүн. Төмөр замын тээвэрээр энэ оны эхний 11 сард 20.5 сая тонн ачаа тээвэрлэж, давхардсан тоогоор 2.4 сая хүн зорчсон байна.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2,425.78
Евро	2,857.33
Япон иен	21.53
ОХУ рубль	41.33
БНХАУ юань	366.83
БНСУ вон	2.23

Эдийн засаг



Энэ онд 130-160 мянган тонн хэмээн төлөвлөж байсан зэсийн үйлдвэрлэл нь ирэх онд 125-155 мянган тонн болж буурна.

байх бол гүний уурхайн бүтээн байгуулалтын зардал 1.1-1.2 тэрбум ам.доллар болж өсөх төлөвтэйг Turquoise Hill Resources танилцуулжээ. Албан ёсны эх сурвалжуудын мэдээлж буйгаар “Оюутолгой”-н ил уурхайн олборлолт ирэх онд 4, 6 дугаар үе шатанд төвлөрөх бөгөөд овоолго дахь хүдэр боловсруулалт ч үргэлжлэх аж. Зэсийн нөөцөөр дэлхийд гуравдугаарт орох тус уурхайн олборлолт 2025 онд түүхэн дээд хэмжээнд хүрч, жилд 550 мянган тонн хүрэх юм. Тэрчлэн Дубайн гэрээтэй холбоотойгоор ирэх онд “Оюутолгой”-д аудитын шалгалт оруулахаар болсныг албаны эх сурвалжууд мэдээлж байна.

● **Үндэсний аудитын газар Олон улсын аудитын байгууллагуудтай хамтарч, Дубайн гэрээнд аудит хийхээр болов.**

● **“Оюутолгой” алтны хүдрийн олборлолтоо ирэх онд энэ оныхоос хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа аж.**


ЗГМ©

“Оюутолгой” зэсээ хумьж, алтаа арвижуулна

“Оюутолгой” ирэх онд улсын төсөвт 406 тэрбум төгрөг төлнө гэсэн хүлээлттэй

Энэ оны гуравдугаар улирлын байдлаар улсын төсөвт 120.5 сая ам.долларын татвар, бусад төрлийн төлбөр төлсөн “Оюутолгой” ирэх онд 406 тэрбум төгрөг төлнө гэсэн хүлээлт давамгайлж буй. Түүгээр ч үл барам Сангийн яамны уул уурхай, газрын тосноос олно гэж үзэж буй хоёр тэрбум орчим төгрөгийн тэн хагасыг зэсээс олно гэсэн найдвар тээж

байгаа юм. Үүний бараг тал хувь “Оюутолгой”-д ногдох нь. Үүнээс гадна, гүний уурхайн бүтээн байгуулалт нь ид өрнөж буй “Оюутолгой” алтны хүдрийн олборлолтоо ирэх онд энэ оныхоос хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа аж. 240-280 мянган унц алт олборлоно гэдгээ Turquoise Hill Resources компани хэд хоногийн өмнө мэдэгджээ. Гэхдээ энэ онд дунджаар 1250 орчим ам.долларт хэлбэлзэж байгаа алтны ханшийг томоохон аналитууд тийм ч таатай гаргаагүй. Дэлхийн банк л гэхэд геополитикийн болон байгалийн гамшгийн хүчин зүйлийн нөлөөгөөр нэг унц алт дунджаар 1206 ам.доллар байна гэж таамагласан. “Оюутолгой”-н алтны хүдрийн олборлолтын энэ



оны биелэлт 60-80 хувьтай байгаа аж. “Оюутолгой”-н хувьцаа эзэмшигч Turquoise Hill Resources-ийн толгой компани болох Rio Tinto групп ирэх онд зардлаа танаж, төсвийн сахилга батад онцгой анхаарах төлөвтэй байгаа юм. Энэ сарын эхээр томилогдсон

ТУЗ-ын шинэ тэргүүн болох Саймон Томпсон одоо байгаа төслүүдээ урагшлуулахад онцгойлон анхаарч, хувьцаа эзэмшигчдэд тараах ногдол ашгаа нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарна хэмээн мэдэгдсэн. Тиймдээ ч энэ оны эцэс болон ирэх онд зардлуудаа танахаар

төлөвлөж буй. Наймдугаар сард таван тэрбум ам.доллар байна гэж таамаглаж байсан капиталын зардлаа оны эцэст 4.5 тэрбум ам.долларт барихаар төлөвлөж буй бол үйл ажиллагааны зардлаа ч 2.8 хувиар бууруулж, 700 сая ам.доллар болгохоор чармайж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалт нь эд өрнөж буйтай холбоотойгоор “Оюутолгой” тоног төхөөрөмж худалдаж авахад ихээхэн зардал гаргасан. Мөн хүдрийн агууламж багасаж, ложистикийн өртгөөс шалтгаалж үйл ажиллагааны зардал нь өссөн юм.

Мөн ил уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор үндсэн хөрөнгийн зардал ирэх онд дунджаар 150 сая ам.доллар

Улс орны эдийн засагт голлох нөлөөг үзүүлдэг томоохон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ирэх онд аудит хийхээр төлөвлөвд байгаа. Энэ хүрээнд “Эрдэнэс Таван толгой” хувьцаат компани болон “Оюутолгой” компанид иж бүрэн аудит хийх юм. “Оюутолгой”-н хөрөнгө оруулалтын болон далд уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө нь Монгол Улсын эрх ашигт нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах аж. Үүнтэй холбоотойгоор эхний ээлжинд Дубайн гэрээнд аудит хийхээр болж байна. Үндэсний аудитын газар Олон улсын аудитын байгууллагуудтай хамтарч, тусгайлан горимоор уг гэрээнд аудит хийхээр хэдийнэ төлөвлөжээ. [ЗГМ]

MSE ALL 1.71 хувиар буурчээ



Монголын хөрөнгийн MSE ALL индекс даваа гарагт 1.71 хувь болж 1146.7 нэгж болж буурав. Тус индекс энэ сарын 1-нд 1329.37 нэгж буюу түүхэн дээд түвшинд хүрч байсан юм. Даваа гарагт арилжаанд 27 хувьцаат компанийн 197.5 мянган ширхэг хувьцаа оролцсоноос 14 компанийн хувьцаа өсөж, долоон компанийнх буурсан байна. Харин бусдынх нь тогтвортой байжээ. “Силк нет”, “Жинст Увс” компанийн

хувьцаа хамгийн өндөр буюу 15 хувиар өссөн бол “Дархан хүнс” компанийнх 13.29 хувиар уруудсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 114 ширхэг үнэт цаас 11.2 сая төгрөгөөр арилжаалагдаа. Мөн компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 200 ширхэг үнэт цаас 20.0 сая төгрөгөөр нээлттэй худалдаанд оролцсон байна. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	71.43	▲ +1.22%	12/18/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▼ -5%	12/18/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	9	▲ +4.35%	12/18/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.01	▼ -9.09%	12/18/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	12/18/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.11	▼ -7.22%	12/18/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.94	▲ +1.81%	12/18/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.18	▼ -2.7%	12/18/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.64	▼ -4.48%	12/18/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.28	▼ +3.7%	12/18/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1259.03	▲ +0.21%	12/18/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	902	▲ +1.42%	12/18/2017
МӨНГӨ	SIA	унци	16.155	▲ +0.57%	12/18/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	311.9	▼ -0.49%	12/18/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	69.09	▲ +0.14%	12/18/2017
WPI TOS	CLA	баррель	57.53	▲ +0.4%	12/18/2017
БРЕНТ	COA	баррель	63.4	▲ +0.27%	12/18/2017
БЕНЗИН	XBA	▲ +0.74%	166.7	▲ +0.74%	12/18/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.686	▲ +2.83%	12/18/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	12/18/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	99.95	▼ -0.05%	12/18/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.138	▲ +1.46%	12/18/2017
БУДАА	RRA	центнер	11.72	▲ +0.13%	12/18/2017
БУУДАЙ	WA	бушель	422	▲ +0.9%	12/18/2017
КАКАО	CCA	тонн	1908	▲ +1.65%	12/18/2017
КОФЕ	KCA	фунт	1.222	▲ +1.24%	12/18/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛУ ХК	APU	701.33	▼ -2.26%	12.18.2017
ГОВЬ ХК	GOV	26100	▼ -4.67%	12.18.2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	9000	▼ -10%	12.18.2017
МАХИМПЕКС ХК	MMX	2940	▲ 1.94%	12.18.2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	548.69	▼ -9.59%	12.18.2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20560	▲ 1.28%	12.18.2017
СҮҮ ХК	SUU	248.84	▲ 3.8%	12.18.2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	30000	▼ -5.72%	12.18.2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	8960	◀▶ 0%	12.18.2017
БАГАНУУР ХК	BAN	2299	▲ 8.65%	12.18.2017
ДАРХАН ХҮНС ХК	DHU	4500	▼ -13.29%	12.18.2017
АРИГ ГАЛ ХК	EER	3900	▼ -2.5%	12.18.2017
ГУТАЛ ХК	GTL	21000	▲ 8.19%	12.18.2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	145	◀▶ 0%	12.18.2017
АЙТҮҮЛС ХК	ITLS	198.27	▲ 0.57%	12.18.2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	575	▲ 8.08%	12.18.2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6936.583	+80.06 ▲ +1.17%	12/18/2017
DAX INDEX	DAX	13311.76	+208.2 ▲ +1.59%	12/18/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	16041.98	+25.52 ▲ +0.16%	12/18/2017
S&P/ASX 200	AS51	6038.93	+41.96 ▲ +0.7%	12/18/2017
S&P 500	INX	2675.81	+23.8 ▲ +0.9%	12/18/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3267.923	+1.79 ▲ +0.05%	12/18/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	24651.74	+143.08 ▲ +0.58%	12/18/2017
TOP 20	MSETOP	21322.29	-173.68 ▼ -0.81%	12/18/2017
FTSE 100	UKX	7524.53	+33.96 ▲ +0.45%	12/18/2017
HANG SENG	HSI	29050.41	+202.3 ▲ +0.7%	12/18/2017
NIKKEI 225	NKY	22901.77	+348.55 ▲ +1.55%	12/18/2017